

## *Эрхэм уншигчид аа!*

“Хүний эрх” сэтгүүлийн Редакцийн зөвлөлийн чин сэтгэлийн мэндчилгээг хүлээн авна уу.

Сэтгүүл маань энэ дугаараасаа эхлэн шинэ Редакцийн зөвлөлийн хянан тохиолдуулсанаар Таны гар дээр хүрч байна.

“Хүний эрх” сэтгүүл уншигчиддаа хүрч эхэлсэнээс хойш 5 жилтэйгээ золгож байна. Энэ хугацаанд судлаачид, сонирхогчид, олон нийтийн хүний эрхийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх үүргээ амжилттай биелүүлж, тодорхой бүлгийн хүмүүсийн хүсэн хүлээдэг “мэдлэгийн цомог” болж чадсан.

Редакцийн шинэ зөвлөл “Хүний эрх” сэтгүүлийн хүрсэн амжилтыг бататгахын зэрэгцээ хүний эрхийн онолын судалгааг хөгжүүлэх, салбарын онолчид, судлаачдын оюунлаг мэтгэлцээний талбар байхыг зорьж ажиллах болно.

Хүний эрхийн асуудлыг сонирхон судлагч, эрхэм бичгийн хүн Таны оюуны бүтээлийг олон нийтэд хүргэх гүүр болон ажиллахдаа бид ямагт талархалтай байх болно.

Энэ дашрамд “Хүний эрх” сэтгүүлийг Танд хүргэх боломж олгосон Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр, захиргаа, зохион байгуулалтын харамгүй дэмжлэг үзүүлсэн “Эмэгтэйчүүдийн эрхийн хэрэгжилтийг дэмжих” төслийн ажилтан Д.Урантогост талархалаа илэрхийлж байна.

*Хүндэтгэсэн,  
Д.Солонго*

*(Гарын үсэг)*

*Комиссын дарга,  
Сэтгүүлийн ерөнхий редактор*

**ЦАГДААГИЙН АЖИЛТНУУДЫГ БУРУУТГАСАН  
ДҮРС БИЧЛЭГИЙГ СУРГАЛТЫН АРГА  
ХЭРЭГСЭЛ БОЛГОН АШИГЛАХ НЬ**

**С.Болд, ХЭҮК-ын ахлах референт**

**1. Хүний эрх ба гадаад орны турилага**

<b>Тактик</b>	Сургалт /боловсрол/ ба мэдлэг	<b>Оролцооны хэлбэр:</b>	Сурталчилгаа
<b>Байгууллага</b>	Турк Улсын Цагдаагийн академи	<b>Тактикийг санаачилсан:</b>	Монгол Улсын Засгийн газар
<b>Улс</b>	Турк	<b>Хамруулах сектор:</b>	Цагдаагийн байгууллага

Туркийн цагдаагийн академи сонсогч нарт хүний эрхийн зөрчлийн үр дагаврын талаархи сургалтандаа хүний эрх зөрчсөн цагдаагийн ажилтнуудын үйлдсэн хэргийг шүүхээр шийдвэрлэхдээ дүрс бичлэгийг нилээд ашигласан байна.

Энэ бол сургалтын чухал тактик мөн бөгөөд түүнийг цагдаагийн академийн сонсогчдод зориулсан хүний эрхийн боловсролын томоохон стратегийн нэг хэсэг болгон тэдэнд яллагдагчийн эрхийг зөрчихөөргүй тийм мөрдөн байцаалт, шалгалтын арга барилыг ойлгуулах, үнэлэх, ашиглахтай цогц байдлаар авч үзэхэд ашигладаг байна.

Турк Улс нь цагдаагийн дээд шатны байгууллагад эрх мэдлээ буруугаар /урвуулан/ ашиглах явдлыг арилгах талаар идэвхитэй ажиллаж байгаа бөгөөд энэ ажлыг өндөр албан тушаалтнуудын түвшинд мөн хэрэгжүүлж байгаа билээ.

Хүний эрхийг зөрчсөн гэм буруутай цагдаагийн ажилтныг шүүхээр таслан шийдвэрлэж байгааг харуулсан дүрс бичлэг нь цагдаагийн академийн сонсогч нарт хүний эрхийн талаархи үзэл, ойлголтыг нь зөвтгөх сайхан жишээ болсон төдийгүй хүний эрхийн талаархи буруу ташаа ойлголтыг өөрчлөхөд нь ач холбогдолтой болсон байна.

Сонсогч нар суралцаж байх эхний үедээ хүний эрхийг хүндэтгэх нь нууц хүчнийхэнтэй тэмцэхэд саад тотгор учруулна, гэмт этгээдүүдийг баривчлахын тулд тэд боломжтой бүхий л аргыг ашиглаж болно эсвэл ашиглах ёстой, хүний эрх бол саад тотгор-нууц хүчин гэмт хэрэгтэй тэмцэж байхад бүхий л аргыг хэрэглэж болно, гэмт хэрэгтнүүд бол жирийн хүмүүс биш, хүч хэрэглэх эсвэл ялтанд шахалт үзүүлэх нь цагдаагийн ажилтнуудын үйл ажиллагааны хэвийн хэм хэмжээ, хүний эрхийн асуудал тэдэнд өөрсдөд нь хамаагүй, сонсогч нар тэдний өөрсдийн нь эрх мөн хүний эрхэд хамаатай гэдгийг тэр бүр сайтар ойлгож ухамсарлаагүй байв.

Эрдэмтэн Вахит Бичак хүний эрх зөрчсөн цагдаагийн ажилтнуудын хэргийг шүүхээр шийдвэрлэсэн дүрс бичлэгийн материалуудыг цуглуулах тактик боловсруулсан байна. Тэрээр хүний эрх зөрчсөний төлөө шүүхийн өмнө шийтгүүлж буй ажилтнуудыг харуулсан тэдгээр видео материалаас сонгож 90 минутын бичлэг хийсэн байна. Түүний энэ тактик нь эхлээд эсэргүүцэлтэй тулгарч, шүүхийн бичлэгтэй анхны оригиналь 10 кассет, 90 минутын бичлэгтэй хамт алга болсон байв. Ийм байж болох магадлалыг урьдчилан тооцоолсон эрдэмтэн Бичак зохих бэлтгэлтэй, нөөц бичлэгтэй байсан тул тэдгээрээс ашиглан дахин бичлэг хийсэн байна.

Дүрс бичлэгээс гадна эрдэмтэн Бичак хүний эрхийн талаар академийн сонсогчдын санал бодлыг цуглуулах 10 асуулт бүхий асуулгын хуудас боловсруулж тараасан байна. Эдгээр санал асуулгын хуудсуудыг хүний эрхийн сэдвээр явуулсан 12 сарын хөтөлбөрийн өмнө, мөн дууссаны дараа бөглүүлж авсан байна.

Сонсогчид эдгээр санал асуулгад шууд хариулсан учраас өөрсдийн бодлоо үнэнээр нь бичжээ. Үр дүнг хөтөлбөрийн төгсгөлд хийсэн судалгаагаар гаргасан бөгөөд энэ тактик сонсогчдын зүгээс сэжигтэн, яллагдагчийг ойлгож харьцахад нааштай нөлөө үзүүлсэн

гэдгийг харуулсан. Түүнээс гадна дүрс бичлэг үзсэний дараа сонсогчидтой уулзаж ярилцсан нь тактикийн үр дүнд нааштайгаар нөлөөлсөн гэдгийг ч мөн харуулж чадсан.

Жишээлбэл, санал асуулгын хуудсанд дараах нөхцөл байдал нь мөрдөн байцаалт явуулахад саад тотгор болох уу? Болдог бол яагаад? гэсэн асуулт байсан. Үүнд:

- Сэжигтний мэдүүлэг өгөхгүй байх эрх
- Яагаад баривчлагдсан үндэслэлийг сэжигтэнд хэлж өгөх
- Баривчлагдсан газрын хаягийг гэр бүлийхэнд нь хэлж өгөх
- Эмнэлгийн үзлэгээр оруулах (эрүү шүүлт эсвэл зүй бус харьцаа байсан эсэхийг шалгах)
- Өмгөөлөгч авах эрхийг нь хэлж өгөх
- Өмгөөлөгч байлцуулах болон мэдүүлэг өгөх үеэр зөвлөгөө авах г.м.

Хүний эрх зөрчсөн бол цагдааг ч гэсэн хэрэгт татаж, яллаж болно гэдгийг ойлгуулах, бүх сэжигтэн, яллагдагчид эрхээ хамгаалуулах ёстой гэдгийг тэдэнд мэдүүлэх зорилгоор академийн сонсогч нарт 90 минутын дүрс бичлэгийг үзүүлсэн байна.

Хөтөлбөрийн дараа явуулсан судалгаагаар цагдаагийн үйл ажиллагаанд саад тотгор байсаар байгаа нь тогтоогдсон байна. Энэ нь төгсөгчид хүний эрхийн сургалтаар олж авсан мэдлэг, чадвараа хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж байгаа бөгөөд үйл ажиллагааны тогтсон хэм хэмжээний эсрэг явж байна гэсэн үг юм. Хэр олон сонсогч хүний эрхийн сургалтанд хамрагдана, тэр хэмжээгээр хүний эрхийн талаар ойлголт, мэдлэгтэй болж, хууль тогтоомжийг зөрчсөн үр дагавар нь тэдний болон хамт ажиллагсдынх нь мэдлэгийг улам бэхжүүлэх ач холбогдолтой.

## **2. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үүднээс цагдаагийн ажилтнуудад хүний эрхийн сургалт явуулах**

<b>Тактик</b>	Боловсрол: Тусгайлсан сургалт	<b>Оролцооны хэлбэр:</b>	Сурталчилгаа
<b>Байгууллага</b>	Эрүү шүүлтээс хохирогчдод туслах төв	<b>Тактикийг санаачилсан:</b>	Иргэний нийгэм
<b>Улс</b>	Болгар	<b>Хамруулах сектор:</b>	Цагдаагийн байгууллага

Эрүү шүүлтийн улмаас хохирогчдод туслах төвөөс цагдаагийн ажилтнуудад зориулан эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулж байна. Сургалтын хөтөлбөрт хүний эрх болон эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх тусгайлсан сургалт голлох бөгөөд энэ нь хөтөлбөрийн дараа өөрсдийн бүсийн цагдаагийн газарт хамт ажиллагсдадаа сургах үүрэг бүхий сургагч маягийн ажилтнуудыг бэлддэг байна.

Цагдаагийн балмад үйлдэл, дураараа авирлах явдал Болгар Улсад коммунист дэглэмийн үеэс эхтэй асуудал байсан бөгөөд шинэчлэлийн буюу ардчиллын явцад иргэдийн ялангуяа, цөөнхийн эрхэд халтай хэвээрээ байна. Саяхныг хүртэл хүний эрхийн хэм хэмжээ /хэрэглэж болохуйц/-ний талаархи цагдаа нарын ойлголт мэдлэгийг дээшлүүлэх талаар хамтарч ажиллахаас зайлсхийдэг, цагдаагийн байгууллагууд хүний эрхийн асуудлыг авч үзэхээс татгалздаг, цагдаагийн зарим албан тушаалтнуудын үйлдлээс шалтгаалж хүний эрхэнд ихээхэн хохирол учирч байв.

Эрүү шүүлтийн улмаас хохирогчдод туслах төвийн цагдаагийн сургалтын хөтөлбөр нь хүний эрхийн болон цагдаагийн асуудлаар ерөнхий ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх ажлаар эхэлсэн.

Энэ нь ерөнхий нөлөө, байгууллагын дэмжлэг авах үүднээс хүчний байгууллагын дээд түвшинд зориулсан сургалтаар эхэлсэн. Төвөөс хүний эрхийн ерөнхий асуудлаар цагдаагийн байгууллагуудын 1000 гаруй ажилтнуудад нийтдээ 30 гаруй семинар зохион байгуулжээ. 2001 онд анхан шатны онолын сургалтанд практикийн хичээл нэмж оруулсан нь хамт ажиллагсдадаа хүний эрхийн хичээл заах чадвар бүхий сургагч нарыг бэлтгэх зорилготой

байв. Эдгээр сургагчдын мэдлэгийг гүнзгийрүүлэх, тэднийг хүний эрхийн сургалт зохион байгуулах чадвартай болгох зорилгоор цуврал сургалтуудыг мөн хэрэгжүүлсэн байна.

Тус төв болон цагдаагийн хамтын ажиллагаа нь Европын холбооны шахалт шаардлагын үр дүн бөгөөд энэ нь төвийн тавьсан санаачилгад цагдааг илүү нээлттэй болгосон байна. Европын холбоо болон бусад орнууд хорих газруудыг шалгаж, нээлттэй хяналт шалгалт явуулж эхэлсэн тул цагдаагийн удирдлага зарим нэг өөрчлөлтийг хийх шаардлага тулгарч буйг ойлгож эхэлсэн.

Ингээд төвөөс өөрсдийн оролцооны талаар цагдаагийн газруудад албан бичиг явуулав. Тус төвийн мэдээлснээр хамт ажиллагсадаа хүний эрхийн талаар сургалт явуулах чадвар бүхий сургагч нарыг бэлтгэхэд чиглэсэн тусгайлсан хөтөлбөр нь 2 гол чухал хүчин зүйлгүйгээр хэрэгжих боломжгүй байв. Үүнд: цагдаагийн байгууллагын идэвхитэй хамтын ажиллагаа болон цагдаагийн менежмент, нөгөө талаас хүний эрхийн асуудлыг шийдвэрлэх академик аргыг өөрчилж тусгайлсан, практик сургалтыг илүү дэмжих зэрэг болно.

Тэдний үзсэнээр эхнийх нь сургагч нар хамт ажиллагсадаа сургалтыг үр дүнтэй, амжилттай зохион байгуулсан тохиолдолд зайлшгүй, харин хоёр дахь нь хүний эрхийн сэдвээр онолын буюу академик сургалтад анхаарахаас илүү хандлага, зан байдлыг өөрчлөхөд /менталитет/ нь туслах, сургалтыг илүү хүртээмжтэй болгох ач холбогдолтой байв.

Сургалт нь цагдааг буруушаах биш, дэмжлэг үзүүлсэн үйл ажиллагаа гэж ойлгож болно. Төвийн туршлагаас харахад офицерууд буруутай гэдгээ мэдэрвэл өөрсдийгөө хамгаалах шинжтэй болж ирдэг. Семинарыг бүх оролцогчдод хүндэтгэлтэй хандсан, бүгдэд нь өөрсдийн санаа бодлоо хэлэх боломж олгогдсон байхаар бодож зохион байгуулахын зэрэгцээ сургалтанд оролцогчид өөрсдийгөө өөрчлөх тийм орон зайг бий болгох боломж олгохыг зорьдог. Төв нь цагдаагийн ажилтнуудад бурууг тохохын оронд хувь хүний үйлдэл, зан байдлыг авч үзэхээс урьтаж, явц хэтийн төлөв байдлыг харах нь чухал байв.

Тус төвийн цагдаад зориулсан эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх сургалтын хөтөлбөр нь зөвхөн цагдаа төдийгүй Болгар Улсын хууль хяналтын байгууллагуудын хүрээнд хүний эрхийн талаархи ойлголт, мэдлэгийг дээшлүүлэхэд ихээхэн ач холбогдолтой болсон байна. Хууль хяналтын байгууллагуудын нийт 65 ажилтан эхний 2 семинарт, 58 ажилтан 3 дахь семинарт 28 бүсийн цагдаагийн сургагч нартай хамт оролцсон байна. Эдгээр ажилтнуудаас олонхи нь хамт ажиллагсадаа хүний эрхийн сургалт зохион байгуулжээ.

Энэ арга хэмжээ ихээхэн амжилттай хэрэгжсэн ч төвийн тухайд хүний эрхийн сургалтын хөтөлбөрийн хүрээнд ихээхэн бэрхшээлтэй тулгарч байв. Цагдаагийн сургагч багшийг бэлтгэх тогтолцоо бүсийн түвшинд улам төгөлдөржиж, тогтвортой болж байхад ихэнх сургалт эрүүгийн цагдаагийн ажилтнуудад зөвхөн эхлэл төдий байснаас гадна сүлжээнээс гадуур гэмт хэрэгтэй тэмцэх үүрэг бүхий цагдаагийн /хүчний/ бараг ихэнх ажилтнуудад хүрээгүй байна. Түүгээр ч барахгүй сургалт явуулах талаар оролцогчдод үүрэг болгосноос хойш олон сургагчид өөрсдийн ажлын ачаалал, чөлөө заваас болоод сургалтын арга хэмжээг зохион байгуулж чадаагүй байна. Төв энэ байдлыг цаашдын сургалтандаа харгалзан үзсэн болно. Хүний эрхийг дэмжих нь нэмэлт үүрэг биш, энэ бол тэдний өдөр тутмын ажлын нэг чухал бүрэлдэхүүн хэсэг байх ёстой гэдгийг ойлгуулахыг хичээж байв.

Өөр нэг хүндрэлтэй асуудал нь хандлага буюу “цагдаагийн соёл”-ын асуудал юм. Хуучин сахилгын аргаас холдох, зүй бусаар харьцах явдал байж болшгүй гэдгийг ойлгуулахыг төвийнхөн хичээж байна. Нөгөөтэйгүүр зарим сургагч нар хүндрэлтэй тулгарсан тохиолдол гарсан. Учир нь зарим хамт ажиллагсад нь хүний эрхийн сэдвээр ярих, авч хэлэлцэхийг эсэргүүцэж байхад, зарим нь сургалтын тоног төхөөрөмж хомс, эсвэл огт байхгүй зэрэг хүндрэл бэрхшээл байсаар байна.

### **3. Цагдаагийн хүчинтэй хийх олон нийтийн яриа хэлэлцүүлэг**

Урт хугацааны олон нийтийн хэлэлцүүлэг явуулснаар энгийн иргэд цагдаатай хамтарч хүний эрхийн гомдол болон цагдаа, орон нутгийн бүлгүүд хоорондын харилцаатай холбоотой бусад асуудлуудыг шийдвэрлэх боломжтой.

Ихэнх орнуудад байдаг маргаантай асуудлын нэг нь цагдаа, иргэдийн хоорондын харилцаа байдаг. Иймэрхүү таарамжгүй харилцаа холбоо нь зүй бус харьцааг бий болгох улмаар нийгмийн хэв журам алдагдахад хүргэдэг. Нигер Улсад энэ асуудлыг шийдэх шинэлэг аргыг хэсэг хүмүүс бодож олсон байна.

CLEEN буюу Нигер Улсын хууль сахиулах байгууллагын боловсролын төвөөс олон нийтийн хэлэлцүүлэг /форум/-ийг бий болгосон бөгөөд энд гэмт хэрэг, цагдаагийн үйл ажиллагаатай холбоотой асуудлууд, өргөдөл гомдлыг иргэд, цагдаатай хамтарч хэлэлцдэг байна.

Нутгийн иргэд, цагдаа нар бие биедээ итгэдэггүй бөгөөд тэд цагдаагийнхныг дураараа, хэрцгий авирладаг, хээл хахуульд идэгдсэн гэж үздэг бол цагдаагийнхан тэдэнд таагүй ханддаг бөгөөд мөрдөн байцаалтын явцад хамтарч ажилладаггүй гэсэн дүгнэлттэй байдаг.

Нигер Улсад цагдаагийн төвлөрсөн бүтэц байгаа нь асуудлыг улам хурцатгаж байна. Иймээс хэлэлцэх асуудал, бодлого нь цагдаагийн хууль сахиулах үйл ажиллагааны давуу эрх болон орон нутгийнхны хэрэгцээ шаардлагын хоорондын ялгаа /зөрчил/-г бий болгоод байгаа бөгөөд энэ нь улс орны хувьд нийтлэг асуудал болоод байна.

CLEEN орон нутгийн засаг захиргаанд албан захидал илгээж орон нутагтаа олон нийтийн форум байгуулах саналыг тэдэнд дэвшүүлсэн байна. CLEEN зөвхөн орон нутгийн захиргаа хариу ирүүлсэн, орон нутгийн цагдаагийн хамтын ажиллагаа, амлалт биелэгдсэний дараа дараагийн шатны арга хэмжээ буюу явуулсан захидлын мөрөөр арга хэмжээ авч ажилласан байна. Ингээд түншлэлийн семинар зохион байгуулж цагдаа, орон нутгийнханд зөрчилтэй асуудал шийдвэрлэх талаар сургалт явуулахын зэрэгцээ орон нутгийнхны өргөдөл гомдолд өгч буй цагдаагийн хариу арга хэмжээ, CLEEN-ний хөтөлбөрийг хэрхэн хэрэгжүүлэх асуудлаар ярилцаж, санал бодлоо солилцсон байна. Эдгээр арга хэмжээ нь CLEEN-ний хөтөлбөрийг өөрсдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэх боломжийг орон нутгийн бүлгүүд олгосон. Орон нутгаас форумын үйл ажиллагааг зохицуулах 2 хүнийг 2 жилийн хугацаатай хагас цагаар ажиллуулахаар хөлсөлж авсан байна. Харин 2 жилийн дараа тухайн орон нутгийн бүлгүүд хөтөлбөрийг өөрсдийн хэрэгцээнд нийцүүлэн тогтвортой хэрэгжүүлэх боломж, арга замыг хайх хэрэгтэй болсон.

Энэ тактикаар орон нутгийнхан болон цагдаад өөрсдийн үзэл бодлоо хуваалцах, хүнд суртлаас үүдэлтэй саад бэрхшээлүүдийг хамтдаа даван туулах тийм найрсаг, хамтач орчинг бий болгож бүрдүүлсэн байна. Аль аль нь маргаантай харилцаатай бөгөөд бусдыгаа илүү хүнлэг байдлаар харж харьцах, сөрж эсэргүүцэхээсээ илүү хамтарч ажиллах боломжтой болсон. Цагийн аясаар энэ үйл ажиллагаа нь үл итгэлцэх, бүтээлч бус харилцааг таслан зогсоож цагдаа иргэдэд үйлчлэх ёстойгоо ойлгосон, иргэд нь цагдааг үүргээ гүйцэтгэхэд нь туслах шинэлэг орчны үндэс суурийг нь тавьж өгсөн. Ингэснээр цагдаагийн хүчирхийлэл, иргэдийн гэмт хэргийг бууруулж чадсан байна. Энэхүү төслийг Нигер Улсын газарзүйн 6 бүсээс сонгож авсан орон нутгийн засаг захиргааны 14 бүсэд хэрэгжүүлжээ.

Үл итгэлцэх, үл ойлголцох нь нийгмийн бусад хэсгүүдэд мөн асуудал үүсгэдэг учраас энэ тактикийг зөрчилтэй байгаа бусад хэсгүүд, тухайлбал үндэстний цөөнх, бизнес эрхлэгчид болон тариачдын хооронд бат бэх харилцаа холбоо бий болгоход ашиглах бүрэн боломжтой. Нэг гол бэрхшээлтэй асуудал нь хүнд хэцүү асуудлуудаас үүдэлтэй сэтгэлийн хөөрөл, хорон үг эсвэл егөөдөл юм. Туслан зохицуулагчид иймэрхүү нөхцөлд ажиллах бүрэн бэлтгэлтэй байхаас гадна нилээд урт хугацаанд иймэрхүү зарчмаар ажиллах шаардлагатай болдог. Зөвхөн нэг удаагийн хурал зэрэг нь CLEEN-ний урт хугацааны арга зам /тактик/-ын үр дүн, үр нөлөө бага байх нь ойлгомжтой.

#### **4. Урт хугацааны, эрчимтэй мониторинг**

Хөдөлмөрийн нөхцлийн талаар үндэстэн дамнасан компаниудтай гэрээ байгуулах Coverco буюу корпорацийн мэргэжлийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг шалгах комиссоос үндэстэн дамнасан компаниудыг хилийн чандад бараа нийлүүлдэг үйлдвэрүүддээ мэргэжлийн ёс зүйгээ чанд хэрэгжүүлж, хүний эрхийг дээдэлж, ажиллахыг уриалсан байна.

Тус Комисс хүний эрхийг зөрчсөн бизнесийн аливаа үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг цуглуулах, шалгах, үр дүнгийн талаар бие даан хэвлэн нийтлэх зэрэг үйл ажиллагааг явуулдаг байна.

Тус Комисс нь Гватемал дахь хувцасны болон хөдөө аж ахуйн экспортын үйлдвэрүүдэд хөдөлмөрийн нөхцөл байдлын талаар урт хугацааны, эрчимтэй, бие даасан мониторинг хийж энд олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээг хэрхэн хэрэгжүүлж байгааг шалгасан байна. 1997 онд иргэний нийгмийн байгууллагуудын гишүүдийн санаачилгаар байгуулагдсан Комисс нь удирдлагад зөвлөгөө өгөх эсвэл ажилчдын эрх ашгийг хамгаалах үйл ажиллагаа явуулдаггүй хараат бус мониторингийн байгууллага бөгөөд Гватемал хотод байрладаг. Тэд эхлээд Лиз Клэйборн зэрэг компанитай ажил төрлийн холбоо тогтоосны дараа үйлдвэрлэлийн бүсэд бүрэн хэмээгээр, шууд нэвтрэх талаар тохиролцоонд хүрсэн байна. Үйл ажиллагааны үр дүнгийн талаарх мэдээллийг өөрийн вэб сайтад байрлуулдаг.

Богино хугацаанд үйлдвэрүүд дээр очиж үзэх, нэг удаагийн тайлан бэлтгэхээс илүү тэдгээр үйлдвэрүүд дээр байнга очиж, доор хаяж 6 сарын хугацааг хамруулж мониторинг хийхийг тэд илүү чухалчилдаг байна. Тэд түргэн зуур зураг дараад өнгөрөхийн оронд үйлдвэр дээрх хөдөлмөрийн харилцааг газар дээр нь “ажлын байрны зураг” авч баримтжуулдаг. Тусгайлан бэлтгэгдсэн мониторч урьдчилж мэдэгдэлгүйгээр сард хэд хэдэн удаа үйлдвэрүүд дээр очдог. Мониторчид үйлдвэрийн тайлан, мэдээ баримттай танилцаж, тулгарч буй асуудлаарх албан ёсны бодлогоо удирдлагад танилцуулахын зэрэгцээ үйлдвэрийн шат дамжлагуудыг “мэдэрч шалгах”-аас гадна ажлын цагт эсвэл дараа нь ажилчидтай уулзаж ярилцах мөн ажилчдад тэдэнтэй шууд харьцах боломж олгох үүднээс “итгэлийн утас” нээн ажилуулдаг. Ярилцлага испани хэл дээр явагдах бөгөөд нууцлалыг нарийн чанд хадгална. Үйлдвэрийн газарт нэвтрэх, удирдлага, боловсон хүчин болон ажилчидтай холбоотой бүх баримт материалтай бүрэн танилцах эрхийг үндэстэн дамнасан корпорацийн удирдлага олгож баталгаажуулдаг.

Мониторинг “нийгмийн аудит” буюу өөрөөр хэлбэл үйлдвэрлэл дээрх хөдөлмөрийн харилцааг тодорхойлох, өргөдөл гомдол гаргах журам байгаа эсэх, хэрэв байдаг бол тэр нь хэрэгждэг эсэхийг нь шалгах аас эхэлдэг. Ажлын явцыг нухацтай баримтжуулна. Үүнд: үйлдвэрлэлийн орчинд химийн бодисууд байгаа эсэх тэдгээрийг хэрхэн хадгалдаг эсэх, шүршүүр байгаа эсэх, ашигладаг эсэх, ажлын байран дахь эрүүл мэндийн анхаарал халамж /талбайн/ болон эрүүл мэнд, аюулгүйн ажиллагааны бусад дүрэм, журамд нийцэж байгаа эсэхийг сайтар шалгаж баримтжуулна.

Дараа нь цалингийн цэс, төрөл бүрийн урамшуулал, хангамж төлсөн байдал, илүү цагаар ажиллах журмыг хэрхэн мөрдөж байгаагаар танилцана. Түүнчлэн, ажилчдын тавьж байгаа гомдлыг маш анхааралтай авч үзэхийн зэрэгцээ гомдлыг шалгаж болохооргүй нөхцөл байдлын талаар анхааруулаад удирдлагын саналыг бүх тайланд оруулна.

Coverco-ийн мониторинг, хяналт шалгалтын үр дүнд томоохон корпорациуд өөрсдийн ханган нийлүүлэгчдээ хөдөлмөрийн хууль, дүрэм, журмыг системтэй мөрдөж ажиллахыг үргэлж шаардах болсон байна. Жишээ нь, уурхайн нэгэн ажилчинд орон нутгийн хууль тогтоомж болон Лиз Клэйборны мэргэжлийн ёс зүйн дүрэмд зөвшөөрсний дагуу өглөө эрт хичээлд суухыг менежер нь зөвшөөрөөгүй талаар тус компанийн удирдлагад гомдол гаргажээ.

Coverco уг асуудлыг баримтжуулсны дараа компанийн удирдлагад танилцуулж, хууль тогтоомжийг дагаж мөрдөж ажиллахыг ЛК инк-ийн удирдлагаас орон нутгийн бүх менежерүүдэд даалгасан байна. Үүнээс үүдээд Coverco уул уурхайн бүх компаниудын нөхцөл байдлыг шалгасан. Ингээд орон нутгийн ханган нийлүүлэгч компаниуд уурхайн ажилчид эцэг, эхийн хувьд гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага гэр оронд нь ихээхэн дутагдаж байгааг харгалзан тухайн орны хууль тогтоомжтой нийцүүлэн тэднийг 7 хоногт 35-аас дээш цагаар ажилуулахгүй байх арга хэмжээг авч чадсан байна.

Зарим үйлдвэрийн газарт нэвтрэх, түүнчлэн үндэстэн дамнасан корпорацитай нь харилцан тохиролцооор байтал засч залруулах арга хэмжээ авахдаа хойрго хандаж байгаа хүндрэл бэрхшээлийн талаар Coverco өөрийн тайландаа дурьдсан байна. Тухайлбал, нэгэн

үйлдвэрийн газрын удирдлага Coverco-ийн мониторингод харуул хамгаалалтгүйгээр үйлдвэрийн шат дамжлагаар явах, мөн хараа хяналтгүйгээр ажилчидтай уулзаж, ярилцахыг зөвшөөрөөгүй байна.

Баримт материал нь хөдөлгөөнгүй нотлогдсон, үнэн зөв байсан учраас засаж залруулах арга хэмжээ авч чадаагүй ханган нийлүүлэгчдэд хатуу сануулах, донгодохоос гадна үндэстэн дамнасан корпорациуд зарим менежерүүдийг ажлаас нь халах хүртэл арга хэмжээг авчээ. Хууль бусаар халагдсан ажилчдыг эргүүлж ажилд нь томилон, илүү цагаар ажиллахыг бууруулж, олгогдоогүй шагнал урамшууллыг нөхөж олгосон байна. Эдгээр нь эрчимтэй мониторингийн үр дүн мөн.

**МОНГОЛЫН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ ДЭХ  
ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ДҮР ТӨРХ  
ӨЧИГДӨР, ӨНӨӨДӨР**

**Б.Тогтохбаяр, Олон нийтийн харилцааны  
“Public” төвийн захирал, докторант**

Монголын хэвлэл мэдээлэл дэх эмэгтэйчүүдийн дүр төрх гэсэн сэдвийн дор яриа өрнүүлэхдээ одоо ба өнгөрсөн цагт явуулж байсан нийтлэлийн бодлоготой цогцоор авч үзэх нь зүйтэй юм. Түүхийн талаас нь авч үзвэл Монголын хэвлэл мэдээллийн хэрэгсэлд эмэгтэйчүүдийн дүр төрх хэрхэн тусгагдаж ирснийг:

1. 19 дүгээр зууны сүүлч үеийн анхны тогтмол хэвлэлийн үе
2. 1921 оны хувьсгалаас хойшхи үе
3. 1990 оны ардчиллаас өнөөг хүртэлх үе гэсэн 3 үечлэлээр авч үзэж болох юм.

Манай сэтгүүл зүйн түүхийг 19 дүгээр зууны сүүлчээр гарч байсан анхны Монгол сонинуудаас үүсэлтэй гэж үздэг. Тэгвэл манай анхны тогтмол хэвлэлүүдийн нэг “Нийслэл хүрээний сонин бичиг” сонинд анх эмэгтэйчүүдийн талаар нийтлэлийн бодлогодоо тусгаж эхэлсэн байна. Уг сонинд нийтлэгдсэн “Шүүмжлэл” нэртэй өгүүлэлд Наймаа хотын ядуу өрхийн охид бүсгүйчүүдээр өдөрт ганцхан зэс зоосны хөлстэйгээр сангийн юм оёулж, хөдөлмөрийг нь шулж байгаа тухай, “Зарим нэг жинстний явдал” өгүүлэлд Хүрээний хятад худалдаачид ихэс дээдэст тал засах гэхдээ зүс царай сайтай, тэгш сайхан бүсгүйчүүдийг найранд дуулуулж, бүжиглүүлэх нэрээр садар самуунд уруу татаж байгаа зэргийг шүүмжлэн бичиж байсныг дээрх сонирхолтой баримтуудаар жишээлж болно.

Харин 1921 оноос хойшхи “Үнэн” сонин тэргүүтэй хэвлэлд эмэгтэйчүүдийн тэгш эрхийн асуудлыг төрийн бодлогын хүрээнд тууштай сурталчилж, эмэгтэй хүн “Эрийн боол, гэрийн зарц” биш нийгмийн амьдралд адил тэгш оролцоотой, ажиллаж, сурч боловсрох, хөдөлмөрлөх эрхтэй иргэд болохыг ойлгуулах, ухуулан таниулан талд илүү анхаарч байв. Энэ хугацаанд Монгол Улсад олон нийтийн мэдээллийн хэрэгслийн систем бүрэлдэн тогтохдоо эмэгтэйчүүдийн дүр төрхийг нийгэмд эерэг байдлаар бүрдүүлэхэд ихээхэн үүрэг гүйцэтгэж шашин, уламжлалтай холбоотой эмэгтэйчүүдийг ялгаварлах аливаа гадуурхалтыг бүрмөсөн арилгах, эрэгтэй, эмэгтэйчүүдийн эрх тэгш байдалтай болохыг тунхагласан нийтлэлийн бодлогыг төлөвшүүлж чадсан юм.

1926 онд “Эмэгтэйчүүдийн санал”, 1928 оноос “Эмэгтэйчүүдийн эрх”, 1930 оноос “Ажилчин эмэгтэй” нэрээр гарч байгаад “Монголын эмэгтэйчүүд” нэртэй болсон эмэгтэйчүүдийн сэдвээр төрөлжсөн сэтгүүл 1990-ээд оныг хүртэл гарч байсан нь эмэгтэйчүүдийн талаархи аливаа хэвшмэл үзлийг арилгах, нийгэмд эмэгтэйчүүдийн талаар эерэг ойлголт бүрэлдэхэд тодорхой үүрэг гүйцэтгэсэн бөгөөд тэр үеийн үзэл суртлын хатуу хяналт эмэгтэйчүүдэд зарим талаар ашигтай байсан байна.

Харин 1990 оноос хойшхи ардчиллын үед эмэгтэйчүүдийн дүр төрх хэвлэл мэдээлэлд тусгагдахдаа нийгмийн шилжилтийн олон шалтгаанаар социализмын үед хүрсэн байр сууринаас зарим талаар ухарсан нь уламжлал, зан заншил, шашин сэргэж, оюун санааны үнэт зүйл өөрчлөгдсөн, нийгмийн баялгийн хуваарилалт тэгш бус болсон зэрэг олон хүчин зүйлээс хамааралтай гэж дүгнэж болохоор байна.

Өнөөгийн манай олон нийтийн мэдээллийн хэрэгсэл дэх эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн дүр төрхийг авч үзэхэд хүйсийн харьцааны хувьд туйлын тэнцвэргүй байгаа нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн нийтлэлийн бодлогод эмэгтэйчүүдийн амьдралын олон тал, нийгэм дэх идэвхитэй амьдрал, хөгжил дэвшилд оруулж буй хувь нэмрийг зохистой, тэнцвэртэй үзүүлж чадахгүй, нөгөө талаар хэвлэл мэдээллийн нийтлэлийн бодлого хэт улстөржиж, эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшин дэх оролцоо хангалтгүй байгаа зэрэгтэй холбоотой гэж дүгнэхэд буруудахгүй юм.

## **1. Сонинуудын нийтлэлийн бодлого ба эмэгтэйчүүд**

Олон нийтийн мэдээллийн хэрэгслээс онцлон сонинг авч үзье. Нийт сонинуудын мэдээ, мэдээллийн баатруудыг судлаж үзэхэд: дунджаар эрэгтэйчүүд 80 хувь, эмэгтэйчүүд 20 хувийг эзэлж, нийт идэвхитэй мэдээ, мэдээллийн баатар 4 хүн тутмын нэг нь эмэгтэй байна. Нийгмийн хамгийн боловсролтой гэсэн бүлгийг хамруулж, удаа дараагийн судалгаагаар олон нийтэд хамгийн бодитой мэдээлэлтэй гэж тооцогддог өдөр тутмын сонингуудын 5 дугаар сарын сарын 18-аас 25-ныг хүртэлх дугаарт дүн шинжилгээ хийж үзсэнээ сонирхуулья.

Энэ хугацаанд гадаадынхан монголд, казиногийн тухай хуулийн төсөл, зуучлах тавчоогоор дамжин Солонгос Улсад хөдөлмөрийн гэрээгээр явах хүмүүсийн бүртгэл, Дархан-Уул аймгийн Хонгор суманд цианидын хор тархсан, Ерөнхийлөгчийн Солонгост



хийх айлчлал, Асгатын мөнгөний ордын талаархи гэрээ тойрсон асуудал, АН, МАХН-ын дотоод амьдрал, УИХ-ын дарга Ц.Нямдоржийн талаархи Үндсэн хуулийн цэцийн шийдвэр, сонгуулийн тухай хууль зэрэг цаг үеийн халуун сэдвүүдийг хөндсөн 90 нийтлэл, 30 гаруй ярилцлагад жендэрийн анализ хийж үзэхэд эмэгтэйчүүд оролцсон, эсвэл тодорхой хэмжээгээр тэдний асуудлыг хөндсөн мэдээ, нийтлэл дөнгөж 5 байлаа.

Үүнд: УИХ-ын Тамгын газрын ажилтан Ж.Нарантуяа, АН-ын Эмэгтэйчүүдийн холбооны тэргүүн Б.Дэлгэрмаа гэсэн 2 эмэгтэй л улс төр, нийгмийн сэдвээр ярилцлага өгсөн байлаа. Гэтэл Хонгор суманд үүссэн нөхцөл байдлын талаар зөвхөн Онцгой байдлын сайд С.Отгонбаяр гэхэд 26 удаа ярилцлага өгсөн байв.

Ер нь нийт өдөрт тумын сонины мэдээ, ярилцлагын баатруудын хүйсийн харьцаа 4:1 зарим үед цаг үеийн шуугиант мэдээ, мэдээлэлд үүнээс ч илүү зөрүүтэй байгаа нь эмэгтэйчүүд шийдвэр гаргах түвшинд оролцоо багатайгаас шууд шалтгаалж байгаа нь дээрхи ажиглалтаар батлагдаж байна. Гэтэл хүний наймаанд өртсөн, Хятад Улсад нөхөр дагаж яваад оргож ирсэн, Малайз Улсад амь насаа алдсан, Хадгаламж зээлийн хоршооны дампуурал зэрэг үйл явдлууд, “Сапу” компаний хохирогчдын дийлэнхи нь эмэгтэйчүүд байснаар хэвлэл дэх эмэгтэйчүүдийн олонхи нь хохирогч, эмзэг бүлгийнхэн мэт дүрслэгдэж байгаа юм.

Харин шар гэгддэг долоо, арав хоног тутмын сонинд ихэвчлэн мисс, загвар өмсөгч, дуучин, жүжигчин гэх мэт цөөхөн төрлийн мэргэжлийг хамарсан, шийдвэр гаргах эрх мэдэл багатай, нийгмийн хөгжилд шууд хувь нэмэр оруулагч, баялаг бүтээгч бус бүлэг давхаргын эмэгтэйчүүдийн талаархи мэдээлэл давамгайлж байдаг бол хэвлэлийн баатар эрэгтэйчүүд нь улстөрчид, удирдагчид, эрдэмтэн, бизнесменүүд, бөхчүүд зэрэг нийгэмд хамгийн их идэвхи нөлөөтэй бүлгийнхэн байна. Мөн эмэгтэйчүүдийн талаархи сэдвийг хөндсөн нийтлэлийн 30 хүртэл хувь хүйсийнх нь хувьд ялгаварлан гадуурхсан өнгө аястай байгаа явдал төдийлөн өөрчлөгдөхгүй байна. Тухайлбал, нийгэмд хамгийн идэвхтэй байр суурь эзэлж яваа улстөрч эмэгтэйчүүдийн талаархи мэдээллийн дөнгөж 20-30 гаруй хувь нь эерэг мэдээ байхад 70 гаруй хувь нь сөрөг мэдээ байна. Ярилцлага, мэдээнд эерэгээр дүрслэгдэж байгаа эмэгтэйчүүдийн олонхи нь улстөрч, бизнесмен, алдартнуудын эхнэрүүд байгаа нь эмэгтэй хүн нийгэмд идэвхитэй субъект бус туслах үүрэг гүйцэтгэгч мэтээр дүрслэгдэхэд илүү нөлөөлөх талтай юм.

Мөн эмэгтэйчүүдийн чиглэлээр төрөлжсөн “Гялбаа”, “Uptown” болон бусад сэтгүүл ч ихэвчлэн эмэгтэй хүний гадаад байдал, гэр бүл, хүүхэд, гал тогоо, эрүүл мэнд гэсэн хэдхэн сэдвийг хөндсөн нийтлэлийн бодлого явуулж байгаа нь судлаачдын дүгнэснээр **Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл дэх эмэгтэйчүүдийн талаархи хэвшмэл ойлголт** юм.

Эмэгтэйчүүдийг ялгаварласан шинжтэй “Бүсгүй хүн цагаан зээр хоёр нутаггүй”, “Сайхан хүүхэн эрийн чимэг”, “Эмс садарлавал үндэстэн мөхнө” гэсэн утгатай хэвшмэл хэлц үгс хэрэглэх нь шар хэвлэлүүдийн дунд багасаагүйгээр барахгүй харьцангуй чадварлаг сэтгүүлчид ажилладаг, мэргэжлийн, хариуцлагатай, бодитой мэдээлэлтэй гэж олон нийтэд үнэлэгддэг өдөр тутмын томоохон зарим сонины нийтлэлд ч “Бүсгүй хүн богино жолоотон”, “Эмэгтэйчүүд улс төрд том алдаа гаргадаг” гэсэн ойлголт, хэвшмэл үг хэллэг хэрэглээнээс гарахгүй байна.

Жендэрийн мэдрэмжтэй сэтгүүлч бэлтгэх сургалтын үеэр эмэгтэйчүүдийг идэвхтэй мэдээ, мэдээлэлд яагаад бага тусгаж байгаагийн учрыг тодруулахад сэтгүүлчид **“Тэд ярих юмгүй, үйл явдалд дүгнэлт өгөх хэмжээний албан тушаалтай эмэгтэй цөөхөн байдаг, сонирхолтой улс төрчдийн дунд эмэгтэй хүн байдаггүй”** гэх мэтээр тайлбарлаж байсан.

Өдөр тутмын сонины нийгэм, урлаг соёл, эрүүл мэнд, жижиг дунд бизнес зэрэг сэдвээр бэлтгэдэг төрөлжсөн мэдээ, мэдээлэлд эмэгтэйчүүдийн оролцоо улс төр, шуурхай мэдээллийнхээс илүү өндөр 40 хүртэл хувийг эзэлж байгаа нь сайшаалтай ч эмэгтэйчүүд гүйцэтгэгчийн дүрээр дүрслэгдэж байгаа юм.

Үүнээс дүгнэхэд:

Монголын сонинд дүрслэгдэж буй эмэгтэйчүүд нь:

-**Нийгэмд гүйцэтгэгч**

-**Хэлмэгдэн хохирогч**

-**Гэр бүлд орлогыг хүртэгч**

- Туслагч
- Дагагч
- Хүчирхийлэлд өртөгч
- Хамгаалуулагч
- Хүчин мөхөс
- Гоо үзэсгэлэнтэй
- Хүүхэд тээгч, төрүүлэгч, бойжуулагч гэсэн дүр төсөөллийг бий болгож байна.

### **Телевиз, реклам дахь эмэгтэйчүүд**

Телевизийн хувьд арилжааны олон сувгууд үүссэн, нэвтрүүлгээрээ хоорондоо хүчтэй өрсөлдөх болсон нь сэдэв, агуулгын хувьд өргөн цар хүрээтэй болоход эерэг нөлөө үзүүлж байгааг тэмдэглэх хэрэгтэй. Телевиз нь үйл явдлыг дүрсээр үзүүлдгээрээ хөтлөгч, сэтгүүлчийн үзэл бодол нөлөө багатай байдаг нь эмэгтэйчүүдийн дүр төрхийг сониныхоос илүү бодитой, шинэлэг талаас нь дүрслэх боломжийг олгодог.

Сүүлийн үед олны сонирхол хамгийн их татаж байгаа NTV-ийн “Хөдөөгийн баясгалан”, SBN-ийн “Оргил цаг”, NTV-ийн “Болзоо”, МҮОНРТВ-ийн “Гүүр”, С-1-ийн “Эмэгтэйчүүдийн цаг” зэрэг нэвтрүүлэгт оролцогчдын хүйсийн харьцаа сониныхоос илүү тэнцвэртэй, нийгэмд идэвхтэй, бодлого боловсруулахад оролцогч, оюунлаг давхаргын эмэгтэйчүүдийн төлөөллийг түлхүү оролцуулж байгаа нь сайшаалтай. Үүний зэрэгцээ, арилжааны олон телевизийн өрсөлдөөн дундаас сэтгэл зүй, хууль эрх зүй, эрүүл мэндийн зөвлөгөө өгдөг нэвтрүүлэг олноор төрж, мэргэжлийн өндөр ур чадвартай төрөл бүрийн салбарын эмэгтэйчүүдийг олонд таниулахад эерэг нөлөөл үзүүлж байгааг тэмдэглэмээр байна.

Гэхдээ ихэнх телевизийн эмэгтэйчүүдэд зориулсан нэвтрүүлэг хүүхдийн хөтөлбөртэй адилхан өглөө, өдөр зэрэг идэвхигүй, үзэгч цөөтэй цагаар, голдуу гэрийн ажилтай эзэгтэй нарт зориулсан чиглэлээр гарч байгаа нь нөгөө л **Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл дэх эмэгтэйчүүдийн талаархи хэвшмэл ойлголтын нөлөө юм.**

Түүнчлэн, эмэгтэйчүүдийн нэвтрүүлгийг бэлтгэдэг найруулагчдын ярьж буйгаар нэвтрүүлэгт нь хамгийн олон үзэгчтэй оргил цаг олдохгүй, нийгэмд нөлөөтэй, бодлого боловсруулагч эмэгтэйчүүдийг илүү оролцуулах бодлогыг удирдлага нь дэмжихгүй, харин гэрийн эзэгтэй, эхчүүдэд зориулсан агуулга, чиглэлээр нэвтрүүлгээ бэлтгэж гаргахыг шаарддаг байна. Мөн төр, нийгмийн болон эдийн засгийн байдал, төсвийн хуваарилалт, үндэсний соёл, уламжлал зэрэг тулгамдсан асуудлаар хийдэг хэлэлцүүлэг, ярилцлагад эмэгтэйчүүдийг цөөхөн оролцуулдаг явдал байсаар байгаа нь нийгмийн амьдралын амин чухал сэдэв эмэгтэйчүүдэд хамаагүй, зөвхөн эрэгтэйчүүдийн асуудал мэтээр үздэг хандлага ТВ-ийн сэтгүүлчдээс салахгүй байгаагийн илрэл юм.

Харин реклам, клип дэх эмэгтэйчүүд Америкийн судлаач Мерри Гриффитсийн тэмдэглэсэн “Залуу нас, гоо үзэсгэлэн, хөнгөмсөг байдал”-тайгаар дүрслэгддэг. Ихэнх клипийг ажиглахад **залуу, гоо үзэсгэлэнтэй, эсвэл, эх хүн, эзэгтэй, өрөвдөлтэй, алдаж эндсэн, хохирсон эмэгтэйчүүд** дүр зураг нийтлэг байна. Харин МУГЖ Б.Жаргалсайханы тоглосон ганцхан клипэнд ажил хэрэгч, эмэгтэйн нөхрийн тухай үзүүлсэн байв. Рекламны мессеж, зохиомжид ч хэвшмэл сэтгэлгээ зонхилсоор байгаагийн заримаас дурдахад “Охид ариун бол төр ариун” гэсэн үг, “Топ” савангийн рекламд нэгэн залуу хөдөөнөөс дагуулж ирсэн найз охиноо ээждээ танилцуулмагц нөгөө бүсгүй шууд барааны савангаар залуугийн хувцсыг угааж эхлэх гэх мэт.

Барууны судлаачдын тэмдэглэснээр **Олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд эмэгтэйчүүдийн талаархи стереотип** тогтсон байдаг.

Үүнд:

1. Эмэгтэйчүүдийн идеал дүр маш хязгаарлагдмал /ажил хэрэгч эмэгтэй, оффисын ганган бүсгүй, олон нийтийн урлагийн одод гэх мэт/;
2. Эмэгтэйчүүдийн сонирхлын хүрээ бага /өөрийнх нь гадаад байдал, гэрлэлт,гэр бүл, хүүхэд/;

3. Үнэлэмж нь залуу нас; /тиймээс рекламд голдуу залуу бүсгүйчүүд тоглож, дунд болон хижээл насны эмэгтэйчүүдийн дүр төрх ховор байдаг/;
4. Эмэгтэйчүүдийн бүх хөтөлбөр, эмэгтэй сэтгүүлчдийн бүтээл агуулгын хувьд хэвшмэл хандлагатай; /бизнесийн буюу ажил мэргэжлийн хувьд амжилтад хүрсэн эмэгтэйчүүд, уран бүтээлчид, зураач, сэтгэл зүйч зэрэг мэргэжлийнхэн, гал тогоо, моод гэх мэтээр хязгаарлагддаг/;
5. Сонин хэвлэлүүд эмэгтэйчүүдийг сексийн объект, сониучирхал, хэл ам үүсгэгч, ямар нэгэн үнэтэй чамин чимэглэл, эрэгтэй хүний эдийн засаг, бусдын нөлөөн дор амьдрагч мэтээр дүрсэлдэг.

Энэ тодорхойлолт манай Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл дэх эмэгтэйчүүдийн дүр төрхтэй тохирч байгаа юм.

Миний бие “Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо ба олон нийтийн санаа бодол” гэсэн судалгааг 2006 оны 2 дугаар сард нийслэлийн 500 иргэний дунд явуулсан юм. Энэ судалгааны дүнгээс үзэхэд оролцогчдын дийнлэнх буюу **67.7 хувь нь улс төрд эмэгтэйчүүдийн оролцоо бага байгаагийн шалтгааныг чадварлаг эмэгтэйчүүд нийгэмд танигдаагүй** гэж хариулсан байна. Нөгөөтэйгүүр, **эмэгтэйчүүд хүүхдээ өсгөж гэр бүлдээ анхаарах хэрэгтэй, төрийн алба хаших нь эр хүний ажил** гэж 15 орчим хувь нь хариулсан байв.

Үүнээс үзэхэд, эмэгтэйчүүдийг үнэлэх уламжлалт хандлага төдийлөн өөрчлөгдөхгүй, зөвхөн айл гэрийн эзэгтэй гэсэн үзэл хандлага болон олон нийтийн ухамсрыг төлөвшүүлэхэд үндсэн үүрэг гүйцэтгэдэг хэвлэл, мэдээллийн хэрэгслийн нийтлэлийн бодлогын нөлөө ч байгааг тэмдэглэмээр байна. Уг судалгаагаар эмэгтэй хүн нийгмийн хөдөлгөөн, жагсаал цуглаан удирдахыг зөв гэж үзсэн оролцогч маш цөөхөн байсан бөгөөд тэдний 50-иас илүү хувь нь энэ талаар саналаа хэлж мэдэхгүй байна гэж хариулснаас үзэхэд эмэгтэй хүнийг удирдагч гэж хүлээн авах сэтгэлгээ төлөвшөөгүй байгааг харуулж байна.

Харин нийгмийн төлөөх ТББ-ыг эмэгтэйчүүд удирдах нь зөв гэдэг асуулгад 80-аас дээш хувийн санал өгсөн нь эмэгтэй хүнийг нийгмийн сайн сайхны төлөө ажилд идэвхитэй оролцох буюу удирдан ажиллахад л таарна гэж олон нийт үзээд, харин улс төрийн шийдвэр гаргах түвшний өндөр албан тушаал хаших, жагсаал цуглааныг удирдах явдлыг дэмжихгүйгээ тэмдэглэсэн байна.

Судалгааны дүнгээс үзэхэд, олон нийт өнөөгийн улс төрийн тоглолтонд эмэгтэйчүүдийн оролцоо бага байгааг **“Олонд танигдсан чадварлаг эмэгтэй цөөхөн”** гэж тайлбарлаж болох ч, өнөөгийн хамгийн шилдэг эмэгтэй удирдагчийг нэрлэсэн жагсаалтыг тэргүүлэхэд одоогийн алба хашиж байгаа албан ажил хамгийн ихээр нөлөөлдөг байна. Гэтэл одоо өндөр албанд хүрч чадсан эмэгтэй ховор байгаа эргээд нийгэмд танигдаж чадахгүй байгаагийн шалтгаан болж байна. Тэгэхээр шийдвэр гаргах түвшинд гарахын тулд эмэгтэй хүн олон нийтэд танигдах хэрэгтэй, гэтэл өндөр алба хашиж байж л олонд танигдах боломжтой болдог гэсэн урвуу хамаарал харагдаж буйгаас үүдэн **чадварлаг эмэгтэйчүүдийг бодлогоор олон нийтэд танилцуулах, нийгэм дэх эмэгтэйчүүдийн үүрэг ролийг илүү сурталчлан таниулах, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл дэх хэвшмэл ойлголт, хандлагыг өөрчлөх шаардлагатай** гэсэн дүгнэлт хийж болохоор байна.

**ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ АЛАГЧЛАХ БҮХ ХЭЛБЭРИЙГ УСТГАХ  
ТУХАЙ КОНВЕНЦИЙН “ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ӨМЧЛӨХ ЭРХ”-ТЭЙ  
ХОЛБООТОЙ ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТ МОНГОЛД**

**Х.Оюунцэцэг, Монголын Хуульч Эмэгтэйчүүдийн  
Холбооны гүйцэтгэх захирал**

Монгол Улсад хүн амын 51 хувь нь эмэгтэйчүүд байна. Эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс богино насалдаг бөгөөд нэг эмэгтэй хүнд нэг эрэгтэй хүн ноогдож чадахгүй байгаагаас гэр бүл салах, өрх толгойлсон эмэгтэйчүүд бүхий л ажлын хүндийг нугалах үзэгдэл түгээмэл болжээ.

Монгол Улс 1992 оны Үндсэн хуулиараа хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулсан билээ. Төр нь Монгол Улсын иргэдийнхээ өмнө эрх, эрх чөлөөг нь баталгаатай, эрх тэгш эдлүүлэхээр үүрэг хүлээсэн. Үндсэн хуулийн “ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ” 3 дугаар бүлгийн 16.11-д “Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй...” гэж заасан байдаг. Гэтэл энэхүү заалтыг Монгол Улсын Үндсэн хуулиас эрх зүйн хүчин чадлаараа доогуурт ордог хуулиуд зөрчиж байна.

Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцид заасан эмэгтэйчүүдийн өмчлөх эрхийн заалтуудын хэрэгжилт Монгол Улсад ямар байгааг дараах байдлаар авч үзье.

#### 1. АСУУДАЛ 1: ЭАБХУТ Конвенци

- 16/ С “Гэрлэлтийн хугацаанд болон гэрлэлтээ цуцлуулах үед адил эрх, үүрэгтэй байх”
- 16/ D “Гэр бүлийн байдлыг үл хамааран эцэг эхийн хувьд хүүхдийнхээ талаар адил эрх, үүрэгтэй байна. Бүх тохиолдолд хүүхдийн эрх ашгийг нэн тэргүүнд тавина”
- 16/ F “Хүүхдийг асрах, дэмжих, итгэмжлэх, үрчлэх буюу үндэсний хууль тогтоомжид заасан адил төсөөтэй үйлдлийг хэрэгжүүлэхэд адил эрх, үүрэгтэй байх. Бүх тохиолдолд хүүхдийн эрх, ашгийг эн тэргүүнд тавина”

Эдгээр заалтуудыг Монгол Улсын хуульд дараах байдлаар тусгасан. 1999 онд батлагдсан Монгол Улсын Гэр бүлийн тухай хуульд:

- 40.1-д: “Хүүхдэд олгох тэтгэлгийг түүний насны байдлыг харгалзан сард нэг хүүхдэд дараахь хэмжээгээр тогтооно;  
40.1.1-д 11 хүртэлх насны хүүхдэд тухайн бүс нутагт тогтоогдсон амьжиргааны доод түвшингийн 50 хувиар;  
40.1.2-г 11-16 нас /суралцаж байгаа бол 18 нас/-тай болон насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдэд амьжиргааны доод түвшингийн хэмжээгээр;
- Эцэг, эх хүүхдийнхээ өмнө адил, тэгш эрх, үүрэгтэй гэж тус тус заажээ.

Гэтэл уг хуулийн 40.1-д хүүхдийн тэтгэлгийн хэмжээг амьжиргааны доод түвшингийн тодорхой хувийг хүүхдийн настай нь уялдуулан тогтоосон явдал нь амьдрал дээр хүүхэд, эмэгтэйчүүдийн эрхийг хязгаарлан зөрчиж байна. Учир нь 1973 оны Монгол Улсын Гэр бүлийн тухай хуульд хүүхдийн тэтгэлгийг эцэг /эх/-ийн цалин, ашиг орлогын хэмжээнээс хамааран тогтоодог байсан байна.

Одоо дээрхийг үл харгалзан тогтоодог явдал нь Улаанбаатар хотод 11 хүртэл настай хүүхдийн нэг сарын тэтгэлэг гэхэд 20 орчим мянган төгрөг /17 орчим ам.доллар/ болох бөгөөд энэ мөнгө дунд насны хүүхдийн өвлийн гутлын үнэд ч хүрэхгүй. Иймээс ганц бие, өрх толгойлсон, үр хүүхдээ асрамжилж буй эхийн эдийн засгийн болоод тэгш байх эрхийг нь хязгаарласан, ухралттай хуулийн зохицуулалт болжээ гэж дүгнэж байна.

Мөн одоо үйлчилж буй Гэр бүлийн тухай хуулиар хүүхдийн тэтгэлгийг шүүхээс тэтгэлэг тогтоосон өдрөөс эхлэн авдаг бол хуучин /1973 он/ хуульд сүүлийн гурван жилийн тэтгэлгийн мөнгийг нөхөн олгох эрх шүүхэд байсан байна.

Иймд Гэр бүлийн тухай хуульд хүүхдийн тэтгэлийн хэмжээг эцэг /эх/-ийн цалин хөлс, ашиг орлогын хэмжээ, тухайн хүүхдийн хувийн байдлыг харгалзан тогтоох зарчмыг нэмж оруулах нь зүйтэй юм.

Судалгааны дүнгээс харахад нийт гэр бүлийн маргаантай хэргийн 26.6 % буюу 62 нь хүүхдийн тэтгэлэг гаргуулахтай холбогдсон хэрэг, 87.1% нь хүүхэд эхийн асрамжинд үлдэхээр шийдвэрлэгдсэн байна. /Зураг 1,3/

Үүнээс дүгнэвэл, гэр бүлийн маргааны багагүй хувийг эцгээс хүүхдийн тэтгэлэг гаргуулах тухай хэрэг эзэлж байгаа нь эмэгтэйчүүдэд маш их ачааллыг үүрүүлж буй хэрэг юм.

Мөн эцэг эхийн аль нэг нь хүүхдээ тэжээн тэтгэх үүргээсээ зайлсхийж, хүүхдийн тэтгэлгийг төлөхгүй байгаа тохиолдолд тэдгээр эцэг /эх/-д үр нөлөө бүхий хариуцлага хүлээлгэх хэрэгтэй. Гэр бүлийн тухай хуульд тэтгэлэг төлөхгүй байгаа тохиолдолд хоног тутамд төлөгдөөгүй тэтгэлгийн 0.5 хувийн алданги төлөх зохицуулалт байдаг ч ихэнх тохиолдолд энэ хууль хэрэгждэггүй. Иймд албадан хөдөлмөрлүүлэх, баривчлах зэргээр хариуцлага хүлээлгэх зохицуулалт хийх шаардлагатай байна. Монгол Улсын Эрүүгийн хуулийн “Шүүхийн шийдвэр үл биелүүлэх” 258 дугаар зүйлийн 1-д “Хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийтгэх тогтоол, шийдвэр, магадлал, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг санаатай биелүүлээгүй, эсхүл биелүүлэхэд нь зориуд саад учруулсан бол ....” эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заажээ.

Гэтэл шүүхийн шийдвэрлэсэн хэргийн мэдээ, тайлангаас үзэхэд эмэгтэйчүүд хүүхдийн тэтгэлэг төлөхгүй байгаа нөхрийг цагдаад өргөдөл гаргах замаар эрхээ хамгаалах аргыг төдийлөн сайн мэдэхгүй байгаа нь харагдаж байна. Иймд энэ талаар эмэгтэйчүүдэд мэдээлэл өгөх шаардлагатай байна.

## **2. АСУУДАЛ 2: ЭАБХУТ Конвенци**

- 13 дугаар зүйл: /а/ “Гэр бүлийн эд хөрөнгийн болон тэтгэмжийн эрхийг тэгш хүртэх эрхийг Засгийн газар баталгаажуулна”
- 15 дугаар зүйлийн 2-т “Оролцогч улсууд эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдийн адил иргэний эрхийн чадвар, түүнийг хэрэгжүүлэх адил бололцоо олгоно. Тухайлбал, гэрээ байгуулах болон эд хөрөнгөө мэдэж захирах тэгш эрхийг олгож, шүүх, тусгай шүүхэд хэрэг шүүн хэлэлцэх бүх шатанд тэдэнд адил тэгшээр хандана”

Эдгээр заалтуудыг Монгол Улсын хуульд дараах байдлаар баталгаажуулжээ.

- Иргэний хуулийн гуравдугаар бүлгийн 125-133 дугаар зүйлүүдэд гэр бүлийн гишүүдийн хөрөнгийн эрхийг баталгаажуулсан. Уг хуулийн 126.2.3-т ногдол хувь, үнэт цаасыг дундаа хамтран өмчлөх эд хөрөнгөнд тооцогдохоор заасан байна.


Гэтэл шүүх гэрлэлт цуцлах асуудлыг шийдвэрлэхдээ нөхрийн /эхнэр/ нэр дээр буй компанийн хувьцааг гэр бүлийн дундын өмчид тооцолгүй “Компанийн тухай хууль”-иар зохицуулах асуудал гэдэг үндэслэлээр гэрлэлт цуцлахад хувьцааны асуудлыг шийдвэрлэхгүй орхигдуулдаг буруу практик тогтсон. Амьдрал дээр ихэнх тохиолдолд аж ахуйн нэгж, байгууллагын үнэт цаас нөхрийн нэр дээр бүртгэгдсэн байдаг. Компанийн үнэт цаасны оногдох хэсгийн мөнгөн төлбөрийг эхнэрт /хүүхдэд/ олгохоор шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр Баянгол дүүргийн шүүх дээр байхгүй байна.

Иймд гэрлэгсдийн дундаа хамтран өмчлөх эд хөрөнгийг хуваахдаа нөхрийн нэр дээр байгаа үнэт цаас, компанийн хувьцаа болон эд хөрөнгийг тухайн үеийн зах зээлийн ханшаар үнэлж, тэдгээрээс эхнэр хүүхдэд нь оногдох хувийг мөнгөн хэлбэрээр нөхөр /эхнэр/-өөс нь гаргуулах тухай заалтыг Иргэний хууль болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн гэрлэлт цуцлах тусгай зохицуулалтын хэсэгт оруулж хуульчлах шаардлагатай байна.

Мөн бага насны болон хөдөлмөрийн чадваргүй хүүхдийг амьдрал дээр ихэвчлэн эхнэр нь асарч сувилдаг бөгөөд тэдэнд ажил хийж, мөнгө олох боломж байдаггүй. Гэтэл тэд /гэр бүлийн гишүүдээ тэжээгч/ гэрлэлтээ цуцлуулсан тохиолдолд эхнэр, хүүхэд амьжиргааны эх үүсвэргүй үлдэх учраас шүүхээс эхнэрийг ажилд ортол буюу тодорхой хугацаа тогтоон нөхөр тэжээн тэтгэх үүрэгтэй байхаар эрх зүйн орчинг бүрдүүлэх нь зүйтэй.

## **Судалгааны дүн**

Монголын Хуульч Эмэгтэйчүүдийн Холбоо Нийслэлийн Баянгол дүүргийн шүүхийн 2006 онд шийдвэрлэсэн нийт 233 гэр бүлийн маргаантай хэргүүдэд судалгаа хийлээ. Судалгааны дүнг зургаар үзүүлэв.



/Зураг 1/



/Зураг 2/



/Зураг 3/



## **МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ИРГЭДИЙН ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ**

### **Б.Түвшинжаргал, ТЕГДС-ийн багш, магистр**

Дээрх үгийг дурдсаны учир нь Монгол Улсаа гадаадад сурталчилж үнэн зөв мэдээлэл түгээх, олон улс дахь нэр хүндийг өсгөх болон гутаагдсан нэр хүндийг сэргээх тийм ч амар ажил биш гэдгийг илэрхийлэх гэсэн хэрэг.

Монгол Улсын гадаад сурталчилгаанд анхаарал хандуулах хэрэгтэй гэж судлаачид болон иргэдийн нэг хэсэг нь үзэж байхад, нөгөө хэсэг нь дэлхийд томоохонд орох нөөцтэй ашигт малтмалын ордуудыг ашиглаад ирэхээр манай улсын нэр хүнд хүссэн хүсээгүй өснө гэдэг. Гурав дахь хэсэг нь Чингис хаан, түүний байлдан дагууллаас өөр бидэнд гайхуулах зүйл байхгүй гэсэн гутранги, идэвхигүй байр суурийг илэрхийлдэг.

Харин бид Монгол Улсын гадаад сурталчилгаанд онцгой анхаарч, Монголын талаархи үнэнд үл нийцэх мэдээллүүдийг засч залруулах, цаашид тийм мэдээлэл тархахгүй байх нөхцлийг бүрдүүлж эерэг зөв мэдээлэл түгээснээр улс орныхоо Үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэх болно гэж үзэж байна.



Учир нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал бол нийт улс үндэстэн, ард иргэд, нийгмийн хэсэг бүлгийн язгуур ашиг сонирхлын цогц илэрхийлэл бөгөөд Үндэсний аюулгүй байдлын үндсэн хэсгүүд нь өөр хоорондоо нягт уялдаатай, аль нэгийг нь салангид авч үзэж үл болох асуудлууд гэдгийг Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал /цаашид ҮАБҮБ/-аас тодорхой билээ.

Мэдээллийн аюулгүй байдлын тухай ойлголт нь хэвлэл мэдээллийн эрх чөлөө, мэдээлэл хайх, хүлээн авах эрх, төр, байгууллага, хувь хүний нууц, компьютерийн мэдээллийн аюулгүй байдал, мэдээллийн тархалт, түгээлт зэрэг өргөн ойлголтыг багтаасан байдаг. Тиймээс бид ҮАБҮБ-ын дараах заалтуудад гол анхаарлаа хандуулж байгаа юм. ҮАБҮБ-ын 40-д “Мэдээллийн аюулгүй байдал гэдэг нь төрөөс улс орны дотоод, гадаад бодит байдлыг зөв үнэлж, оновчтой шийдвэр гаргах Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардагдах мэдээллээр төрийн байгууллага, ард иргэд хангагдсан, **Монгол Улсын талаар гадаадад мэдээлэл тархах нөхцөл хангагдсан байдлыг хэлнэ**” гэж заасан байна. Мөн ҮАБҮБ-ын 41-д “Мэдээллийн аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөөлж болох гадаад хүчин зүйлүүд дотор: **гадаадын бодит бус мэдээлэл түгсний улмаас** Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлын талаар бусад улсад эргэлзээ төрөх” хэмээн заажээ.

**Мэдээллийн аюулгүй байдлын түвшинг** бодит амьдралын дараах баримтуудаар төлөөлүүлж үзье.

- Microsoft-оос гаргадаг Encarta хэмээх дэлхийд нэртэй электрон энциклопедэд Монголын Улсын газрын зургийг бодит байдалд нийцэхгүйгээр оруулсан байна. Тухайлбал, уг газрын зургаар бол Завхан аймгийн төв нь Зуунмод, Дархан хот Дундговь аймагт, Эрдэнэт хот Хөвсгөлд байдаг байх жишээтэй. Энэ нь жижиг сум сууринг бус, бүхэл бүтэн аймаг, хотуудыг ингэж андуурсан байгаа юм.<sup>1</sup>
- Oxford гэх мэтийн алдартай толь бичгүүдээс Монгол гэсэн үгийн утгыг хайхад Mongolia, Mongol Empire, Mongoloid зэрэг хэдхэн утгууд гарч ирдэг. Харин үүнээс **Монголоид буюу Дауны синдром өвчний тухай**<sup>2</sup> /Монголжуу усан тэнэгрэх/ илүү дэлгэрэнгүй бичсэн байдаг. Өөрөөр хэлбэл, Монгол гэдэг нэрийг гадаадын нилээд хүмүүс Монголоид гэдэг өвчнөөр төсөөлж байна гэж хэлж болох юм.
- К. Маркс XVIII зууны нууц дипломат зохиолдоо “Татаарын дарлал /Орост/ хоёр зуун жил үргэлжилжээ... Тэр дарлал нь гарт нь орсон Оросын ард түмнийг зөвхөн дарангуйлаад зогсохгүй сэтгэл санааг нь хүртэл эвдэн гутаажээ. **Татаар монголчууд** дээрэмдэх, үй олноор нь хядах аргыг хэрэглэн системтэйгээр сүрдүүлэх дэглэм тогтоожээ”<sup>3</sup> гэсэн дүгнэлт хийсэн нь “Монгол Татаарын дарлал” гэсэн сэдвийг хөндсөн бүх бичлэгт салахгүй дагадаг болсон байна.<sup>4</sup> Чингис хааны эцгийг алж, гол өстөн дайсан нь байсан Татаарчууд Монгол гэсэн нэрийг шинжлэх ухааны нилээд ном зохиол, сонин хэвлэлд орлож байна!
- Интернэтийн зарим томоохон порно сайтуудын зургуудад FROM MONGOLIA, ULAANBAATAR, MONGOLIAN GIRLS гэх тайлбар буюу гарчиг өгсөөр байна. Жишээ нь, WWW.WORLDSEX.COM/ search гэх томоохон порно сайтад сүүлийн хоёр жилийн хугацаанд MONGOLIA гэх нэрийг маш томоор байнга гаргах болсон. Дээр нь Да Хүрээ, Дундговь, Зуунмод гэхчлэнгээр манай улсын засаг захиргааны нэгжүүдийн нэрийг тавьсан байдаг нь бүр ч аюултай. Энэ бол зөвхөн бидний үзсэн зүйл, өөр ийм мэдээлэл агуулсан сайт хэд байгааг хэлэх аргагүй байна.
- Мөн Монгол Улсыг **Outer Mongolia** гэж нэрлэж бичих нь түгээмэл байдаг. Энэ нь түүхийн уламжлалтай нэр томъёо байж болох ч Монгол Улсыг “Гадаад Монгол”

<sup>1</sup> [www.encyclopedia.msn.com/encnet/features/mapcenter/map.aspx](http://www.encyclopedia.msn.com/encnet/features/mapcenter/map.aspx)

<sup>2</sup> Дауны синдром буюу монголизм гэсэн нэр томъёог 1866 онд арьс енгээр ялгаварлах үзэлтэй Линдон Даун гэгч гаргасан бөгөөд түүнээс хойш дэлхийн шинжлэх ухааны ном зохиол, сонин сэтгүүлд уг нэр томъёог ихээр хэрэглэх болсон аж. Хиний генетикийн өвчин бөгөөд арьс енгээр ялгаварлах үзлийн улмаас монголжуу гэсэн нэр авчээ.

<sup>3</sup> БНМАУ-ын түүх, УБ, 1955 он, 136-р тал /дам ишлэв/

<sup>4</sup> Баабар, “Монголчууд, Нийдэл суудал”, УБ, 2006 он, 754-755-р тал

хэмээн нэрлэж бичих нь бусад улс үндэстэн, иргэдийг төөрөгдөлд оруулах, **БНХАУ болон ОХУ-ын хязгаар нутаг** гэсэн ойлголтыг төрүүлдэг байж болзошгүй. БНХАУ-ын Өвөр Монголын автономит мужийг **Inner Mongolia** гэж бичдэг нь дээрхтэй хутгалдан ойлгогдох ч магадлалтай.

- Хэдийгээр бид олж хараагүй ч Тайваньд үйлдвэрлэсэн атлас, глобус дээр Монголыг Хятадын нэг хэсэг байдлаар тусгасан байгаад түүнийгээ зах зээлээс эргүүлж татсан гэсэн яриа гарч байсан.
- НҮБ-ын нэгэн хурал дээр хэсэг төлөөлөгчид энэхүү төсөл “Монголд хүртэл хэрэгжсэн”<sup>5</sup> гэж ярилцаж байсан байдаг. Өөрөөр хэлбэл, Монголчууд хэрэгжүүлчихсэн юм чинь бусад ямар ч улс үндэстэн хэрэгжүүлж чадна хэмээн манай улсыг тохуурхсан бололтой.

Энэ мэтээр тоочвол улс үндэстний маань бахархал, иргэдийн нэр төрийг гутаасан мэдээллийн нилээд урт жагсаалт гарч болзошгүй байна.

### **Учир шалтгаан нь юунд оршиж байна вэ?**

Үнэнд үл нийцэх, доромжлолт мэдээллүүд тархаж буй нь дотоод /Монгол Улсын гадаад сурталчилгаа хангалтгүй байдаг, ташаа мэдээлэлд няцаалт өгөхөд хойрго ханддаг/ болон гадаад /гадаадын зарим улс, байгууллагад тийм сонирхол байж магадгүй/ шалтгаантай шууд холбоотой. Дээр дурьдсан Монголоид буюу Дауны синдромтой холбоотой асуудалд 1978 оноос манай улсын Эрүүл мэндийн болон Гадаад хэргийн яам анхаарлаа хандуулж, залруулга хийх ажил багагүй үр дүнд хүрсэн байна. Тухайлбал, 1989 онд ДЭМБ толь бичгээс “монголизм” хэмээх нэр томъёог хасч цаашид хэрэглэж болохгүйг тэмдэглэж, үүний оронд Дауны өвчин гэж албан ёсоор бичиж байх болжээ. Харин энэ ажил 1990 оноос хойш үндсэндээ тасарсан аж.

Түүхэн болон геополитикийн хүчин зүйл ба манай орны улс төр, нийгэм, эдийн засгийн байдлаас шалтгаалан ташаа мэдээлэл тархаж байгаа нь мэдээллийн аюулгүй байдалд сөрөг нөлөөлж буй шалтгаан мөн гэх үндэстэй. Дэлхийн хуурай газрын 1/5-ийг эзэлдэг болон 1.5 тэрбум хүн бүхий хүчирхэг хоёр их гүрэн дундах хүч дорой, цөөн үндэстэн тусгаар тогтнож, тэсч үлдэх эсэх нь мэдээллийн аюулгүй байдлаас ихээхэн хамаарна. Өөрөөр хэлбэл, мэдээллийн асар их түрэлтэд тэсч үлдэх, үндэсний язгуур ашиг сонирхлоо бусдад ойлгуулж, мэдрүүлэх нь гадаад шалтгааны нөлөөлөлтэй шууд холбоотой юм. Том гүрэн том бодлого барьдаг, жижиг гүрэн ухаалаг бодлого барьдаг хэмээн О. Бисмаркийн үзсэнчлэн, бид даяаршлалын нөхцөлд, улс орны гадаад онцлог хүчин зүйлсийн нөлөөлөлд тохирсон мэдээллийн аюулгүй байдлыг хангах бодлогыг оновчтойгоор хэрэгжүүлэх ёстой. Ялангуяа, интернэтийн мэдээлэлд онцгой анхаарал хандуулах хэрэгтэй байна. Доктор, профессор Д. Лүндээжанцан “... төрийн бодлого тусгайлан байдаггүйгээс шалтгаалан интернэтээр цацагдах мэдээлэл нь хугацааны хувьд хоцрогдож, эсхүл **зарим гадаадын гүрнүүдийн улс төрийн холын бодлогын нөлөөнд орох нь бий**”<sup>6</sup> гэж тэмдэглэснийг санууштай.

### **Иргэдийн эрх, эрх чөлөөнд ямар аюул учрах вэ?**

ҮАБҮБ-ын 29-д Иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөөлж болох гадаад хүчин зүйлд:

1/ бусад улсын явуулга, дарамт шахалтын улмаас Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдон баталгаажиг буй ардчилал, шударга ёс, тэгш байдал, иргэдийн эрх, эрх чөлөө зөрчигдөх,

2/ гадаадад алба, амины ажлаар явж байгаа, гадаадад байнга буюу түр оршин суугаа Монгол Улсын иргэдийн эрх, эрх чөлөө хязгаарлагдах, зөрчигдөх, эрх тэгш байдал алдагдах,

<sup>5</sup> Ц.Элбэгдорж, “Нийх ий? Үлдэх ий?” пекцийн видео хувилбар, 2004 он

<sup>6</sup> Д.Лүндээжанцан, “Аюулгүй байдал, хөгжил, төр, эрх зүй”, УБ, 2002 он, 38-р тал

30-д заасан иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөөлж болох дотоод хүчин зүйлд:

3/ нийгэм, эдийн засгийн байдлын улмаас иргэдийн эх оронч сэтгэлгээ алдагдах зэргийг дурджээ.

Тиймээс, мэдээллийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болох хүчин зүйлсийг иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлстэй холбон авч үзэх үндэслэл байна хэмээн үзэж байна.

Юун түрүүнд, Монгол үндэстний талаархи буруу төсөөлөл нэн аюултай бөгөөд хортой үр дагавартай. Буруу төсөөлөл гэдгийг бид үндсэрхэг үзэл, гутранги үзлээс салгаж ойлгож байна. Монголчуудыг дэлхийг байлдан дагуулагчийн хувиар хүндэтгэх ёстой, эсвэл Монголчууд өчүүхэн жижиг буурай үндэстэн гэсэн хандлагыг хүлээн зөвшөөрөмгүй. Харин гадаад, дотоод шалтгааны улмаас үндэстний язгуур ашиг сонирхолд харшлах, илт худал, доромжлол, гүжирдлэгийн шинжтэй мэдээлэл тархсаны улмаас Монгол Улсын нэр хүнд буурч, гадаадын төр, байгууллага, хувь хүний Монгол Улсын иргэдэд хандах хандлага сөрөг болж өөрчлөгдөхийг ойлгож болох юм.

Зарим гадаад орны хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагддаг зуд турхан, халдварт өвчин, нүүдэлчин зэрлэгүүд, траншейны хүүхэд, мөн “Хятадын Монгол” /эсвэл “Оросын Монгол”/-ын тухай мэдээллүүд нь гадаадад ажиллаж, амьдарч, сурч буй иргэдэд хэрхэн нөлөөлдгийг тайлбарлалтгүй бизээ. “Танай Монголд телевиз байдаг юм уу?”, “Махнаас өөр хоол хэрэглэдэг үү?”, “2 давхар байшин байдаг уу?” гэхчилэнгийн гайхсан, басамжилсан асуултууд, эсвэл “үхэр монгол”, “хагас зэрлэгүүд”, “бүдүүлэг нүүдэлчид” зэрэг доромжлолтой байнга тааралддаг гэж болно. Энэ бүхэн нь иргэдийн эрхийг, ялангуяа нэр төр халдашгүй байх, итгэл үнэмшилтэй байх эрхүүдийг шууд зөрчиж байна.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын оршилд: “Хүн төрөлхтний гэр бүлийн бүх гишүүнд угаас заяасан нэр төр болон тэдний тэгш, салшгүй эрхийг хүлээн зөвшөөрөх нь эрх чөлөө, шударга ёс, бүх нийтийн энх тайвны үндэс мөн...” болохыг заагаад 1 дүгээр зүйлд “Хүн бүр төрж мэндлэхдээ эрх чөлөөтэй, адилхан нэр төртэй, ижил эрхтэй байдаг” гэжээ. Үүний нэгэн адил заалт Хүний эрхийн билль болох Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай болон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактуудад<sup>7</sup> тусгалаа олжээ.

Судлаач Х. Тэмүүжин “... Нэр төр гэдэгт орчин үед хууль зүйн утгаараа нэр хүндийн давхардлыг ойлгодог байна. Энэ нь юу гэвэл, хэн нэгний нэр хүндээс шалтгаалан ард нь бас нэг бүтцийн эсвэл олонлогийн нэр хүнд өөрчлөгдөж байдаг тэрхүү нийгмийн үзэгдлийг илэрхийлдэг нэр томъёо болон хувирчээ. Жишээ нь, шүүгчийн нэр хүнд унахад шүүхийн нэр хүнд унадаг гэхчилэн... Иймийн учир нэр төр бол объектив хэлбэр бөгөөд хувь сонирхолд захирагддаг зүйл биш” гэжээ. Үндсэн хууль болон олон улсын хэм хэмжээгээр баталгаажсан хүний халдашгүй эрхийн хүрээнд нэр төрийн халдашгүй эрх нь нэр хүнд<sup>8</sup>, нэр алдар<sup>9</sup> гэсэн үндсэн хэсгүүдээс бүрдэнэ. Эрх зүйн агуулгаараа хүний нэр алдар, нэр хүндэд гүжирдэх, гутаах, доромжлох гэсэн үндсэн хэлбэрүүдээр халдаж болдог.<sup>10</sup> Тэгэхээр, шүүгчийн нэр хүнд унахад шүүхийн нэр хүнд унадаг бол Монгол үндэстний талаархи буруу төсөөлөл нь Монгол Улсын иргэдийн нэр төрийн халдашгүй эрх хөндөгдөх нэг шалтгаан юм гэх бодомж гарч байна.

Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан итгэл үнэмшилтэй байх эрх гэдэг бол аливаа үзэгдэл, үзэл санаа, онол, улс төрийн урсгалд итгэх, шүтэн бишрэх, илэрхийлэх эрх чөлөөг хэлдэг. Агуулгын хувьд үргэлж баяжин өөрчлөгддөг чанараараа итгэл үнэмшил нь

<sup>7</sup> “Хүний эрх, Олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн эмхтгэл”, УБ, 1998 он, 2,8,33-р тал

<sup>8</sup> “Нэр хінд” нийгэмд эерэг үр дагавар, ижилдэг нехцлөөс шалтгаалан буй нэршлийг буюу ёс суртахууны инэлэмжийн тогтворшлыг хэлдэг байна. Х.Тэмүүжин, “Jus Fast буюу ёст ир”, УБ, 1993 он, 22-р тал

<sup>9</sup> “Нэр алдар” бусдаас ялгарах шинжээрээ тигээмэл нэршил олохыг ойлгодог байна. Х.Тэмүүжин, “Jus Fast буюу ёст ир”, УБ, 1993 он, 22-р тал

<sup>10</sup> Х.Эрдэнэбат “Хүний халдашгүй эрх”, УБ, 2002 он, 33-р тал

хүний “нийгмийн харилцааны бүтээгдэхүүн” болох талыг түлхүү харуулна.<sup>11</sup> Үндэстний бахархлыг нь гутаах, улс үндэстнийх нь бүрэн эрхт байдыг /суверенность/ үл хүндэтгэх явдал бол ямар ч эх оронч үзэлтэй иргэнд таатай байхгүй нь мэдээж. Хүний өөртөө итгэх итгэл, эрхэмсэг оршихуй, үнэт зүйлсийн чиг баримжааг гутаах, эвдэх нь хамгийн харгис, бүдүүлэг зүйл ба хүнийг боол, мал адгуустай адилтгаснаас өөрцгүй зүйл юм. Хүн зөвхөн өөрийн итгэл үнэмшил, үзэл бодлын үндсэн дээр нийгмийн харилцаанд оролцож, байр суурь, нэр хүндээ тогтоож чаддаг билээ. Францын нэрт сэтгэгч Морис Мерло-Понти “Итгэл үнэмшлийн зайг үгүйсгэл, нүгэл хоёр эзэлж байгаа ертөнцөд хүмүүс ямар нэгэн юм олж харахыг ерөөсөө зорьж тэмүүлдэггүй” гэсэн нь бий.

“Хуурмаг мэдээллээр хувь хүн, хэсэг бүлэг, олон түмний оюун санаанд нөлөөлж, уг мэдээг бодит үнэн, илэрхий зүйл мэтээр хүлээн авах хүртэл давтан ярьж гажуудуулах нь хүмүүсийн амьдралын баримтлалыг өөрчилж болдог”<sup>12</sup> гэдгийг судлаачид тэмдэглэсээр байна. Хүний нэр төр, итгэл үнэмшилд халдаж байгаа дээрх сөрөг хүчин зүйлүүд нь компьютерийн мэдээллийг гэмтээх, устгах, ажиллагааны өмнө сэтгэхүйд нөлөөлөх мэдээлэл цацах зэрэг мэдээллийн дайнаас илүү алгуур, тогтмол тасралтгүйгээр Үндэстний аюулгүй байдал, түүнчлэн иргэдийн эх орныхоо төлөө гэх сэтгэлгээнд нөлөөлж байгаа гэж үзэх үндэстэй.

Тиймээс, Монгол Улсын Үндсэн хуулийн арванзургадугаар зүйлийн 13-т заасан “иргэдийн нэр төр халдашгүй байх”, 16-д заасан “итгэл үнэмшилтэй байх” эрхүүд болон ҮАБҮБ-ын 40-д заасан “Мэдээллийн аюулгүй байдал гэж... Монгол Улсын талаар гадаадад мэдээлэл тархах нөхцөл хангагдсан байдлыг хэлнэ” гэсэн заалтууд нь эх оронч үндэстний үзэл хэмээх талбар дээр огтлолцдог гэж дүгнэж болох байна.

## **Ямар боломж байна вэ?**

Монгол Улсын иргэн бид төрөлхөөс заяасан үндэс угсаа, түүх соёл, нэр төрөө эрхэмлэж, улам бүр хүндэтгэн алдаршуулах ёстой. Монгол үндэстэн хүн төрөлхтний түүхэнд баттай байр суурийг эзэлдэг, олон орны ард түмэн биднийг хүндэтгэн харьцдаг гэдгийг санах хэрэгтэй. “Чингисийн Монгол”, “баатарлаг хүмүүс” гэдгээр дэлхий дахин төсөөлдөг. Нэг жишээ татахад, Энэтхэгийн төрийн нэрт зүтгэлтэн байсан Индира Ганди “Хинду хэлний “бахадур” буюу эрэлхэг зоригтой гэсэн үг Монгол хэлний “баатар” гэдэг үгнээс гаралтай. Тиймээс, Монгол гэдэг нэр эрэлхэг зоригтой, баатарлаг хэмээх үгээр сэтгэлд минь хоногшсон” гэснийг дурдаж болох юм.

Чечень үндэстнүүд өөрсдийгөө Зүчийн удам гэдэг, зарим нь Монголын “цэцэн” гэсэн үгнээс гаралтай хэмээн хоёр янзаар тайлбарлаж<sup>13</sup> Монголчуудад элэгтэй ханддаг. Афганистаны “Хазаар” хэмээх үндэстнүүд Монгол гаралтайгаараа бахархдаг байна. Шинжлэх ухаан, спорт, урлаг соёлын хүрээнд ч Монголчуудын Лаос, Камбож зэрэг орнуудад манай улсаас хүмүүнлэгийн болон бусад туслалцааг үзүүлж байсныг тус орны иргэд сайнаар дурсдаг гээд тоочвол олон жишээ дурдаж болох.

Өөрийгөө ухаарч, ойлгуулж чадсан үндэстэн л оршин тогтнож түүхэнд ул мөрөө үлдээдэг<sup>14</sup> учир бид анхдагч боломж дээрээ тулгуурлан нийгэм, улс төр, эдийн засаг, оюун санааны амьдралын хүрээний эерэг хандлагуудыг дэлхий нийтэд сурталчлах болон бусдад бий болсон буруу төсөөллийг өөрчлөх боломжоо алдаж болохгүй. Үндэстний аюулгүй байдал бол цаг, минут байтугай секунд долиор хэмжигддэг гэдэг нь даяаршлалын ертөнцөд алхам тутамд мэдрэгдэх боллоо. Үүнийг эс анхаарваас иргэд бидний аюулгүй байдал, эрх, эрх чөлөөний баталгаа бүрдэх эсэх нь мөн секунд, долиор хэмжигдэх болно.

<sup>11</sup> “Монгол Улсын Үндсэн хуулийн нэр томёоны дагалга”, УБ, 1993 он, 22-р тал

<sup>12</sup> Ш.Паламдорж “Мэдээлийн дайн тийнээс хамгаалах”, УБ, 2003 он, 60-р тал

<sup>13</sup> Д.Лхаашид “Монголын нийгэм, төрийн аюулгүй байдал, Монгол хийнийг хөгжүүлэх философи”, УБ, 1996 он, 62-р тал

<sup>14</sup> Д.Линдээжанцан, “Аюулгүй байдал, хөгжил, төр, эрх зүй”, УБ, 2002 он, 71-р тал

## Ямар арга зам байж болох вэ?

Чингис хааны бий болгосон Монгол үндэстний бахархал, Монгол соёл иргэншил дэлхий дахины бидний талаарх төсөөллийг өнөө хэр нуруун дээрээ үүрч явна гэхэд хилсдэхгүй. Үүнтэй нэгэн адилаар нийгэм, эдийн засаг, улс төр, оюун санааны хүрээнд мэдээллийн аюулгүй байдлын дархлаа бий болгох хэрэгтэй. Наад зах нь, жижиг цуурхал хэлбэрийн мэдээлэлд автахаргүй үндэсний мэдээллийн механизм бий болгох нь нэн чухал байна. Ялангуяа, шинжлэх ухаан, технологи, эдийн засаг, мэдээллийн салбарт дэлхийн улс орнуудаас хөгжлөөр хоцрохгүй байх нь үндсэн зорилт байх нь ойлгомжтой.

ҮАБҮБ-ын дагуу “Үндэсний аюулгүй байдлын үндсэн баталгаа нь Монголын ард түмэн өөрөө, Монгол Улсын төр мөн”, “Үндэсний аюулгүй байдлыг хангах гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг, сонирхлыг хамгаалан бэхжүүлж тал бүрийн баталгаа буй болгоход чиглэсэн төрийн бодлого, төр, түүний байгууллага, албан тушаалтнаас авч буй, иргэдээс хэрэгжүүлж буй арга хэмжээг хэлнэ”. Тиймээс мэдээллийн аюулгүй байдлыг хангах арга зам нь дээрх үндэсний шинжтэй заалт дээр суурилах ёстой.

Орчин үед давамгайлж буй төрийн тухай кибернетик хандлагаар бол мэдээлэл түгээх болон буцаах холбооны онцгой тогтолцоог төр гэж ойлгож байна. Мэдээллийг нийтлэг эрх ашгийн үүднээс удирдан жолоодох нь нийгмийн өөрийнх нь хэрэгцээ байдаг. Иймээс мэдээллийн урсгалыг түгээх болон эргэх холбооны тусламжтайгаар жолоодож, мэдээллийн тэнцвэрийг бий болгох, хамгаалах замаар нийгмийн жолоодлогын нөхцлийг бүрдүүлэх үүргийг төр гүйцэтгэдэг гэж үздэг.<sup>15</sup>

Мэдээллийн аюулгүй байдалд сөрөг нөлөөлж болох гадаад хүчин зүйлсийн нөлөөллийг арилгахад чиглэсэн дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх, боловсронгуй болгох, идэвхижүүлэх зайлшгүй шаардлагатай гэж бид үзэж байна. Үүнд:

- Дэлхийн нэртэй томоохон толь бичиг, лавлах, интернет сайтуудад өөрийн орны талаар үнэн зөв мэдээллийг гаргаж өгөх; Жишээ нь, Encarta-н электрон хувилбар жил бүр шинэчлэгдэн гардаг бол, Wikipedia хэмээх хамгийн том интернетийн нэвтэрхий толь өдөр бүр шинэчлэгддэг.
- Толь бичиг, ном, интернет хуудсуудад гарсан буруу ташаа мэдээллийг залруулах, устгах боломжийг судлах;
- Дипломат арга зам, няцаалтыг сайтар ашиглах;
- Ардын дипломат бодлогыг хөхиүлэн дэмжих; Иргэд өөрсдөө эрх, эрх чөлөөний болон үндэсний үзлийн мэдрэмжтэй байж гэмээнэ ардын дипломат бодлого үр дүнтэй хэрэгжинэ.
- Буруу ташаа мэдээлэл тараасан этгээд монголчуудаас өөрөө уучлал эрж, залруулга хийж байх тогтолцоо буй болгох; Иргэн нэр төрөө сэргээлгэхийн тулд гэм буруутай этгээдийг шүүхэд хариуцагчаар татах шаардлага гаргадгийн нэгэн адилаар улс үндэстний нэр сүрийг гутаан доромжлогчдод тийм шаардлага тавих нь зүйн хэрэг.
- Үндэсний эерэг имиж, онцлогийг товойлгосон Монгол Улсын гадаад сурталчилгаанд төрийн зүгээс онцгой анхаарлаа хандуулах;

Эдгээр болон бусад арга замаар ҮАБҮБ-ын 43-т “олон улсын мэдээллийн сүлжээнд нэгдэж орох, Монгол Улсын тухай үнэн бодит мэдээллийг шуурхай түгээх” гэсэн 13 жилийн өмнөх заалтыг амьдрал дээр хэрэгжүүлж, Монгол Улсын иргэдийн доромжлогдсон, зөрчигдсөн эрхүүдийг сэргээн эдлүүлье.

<sup>15</sup> Н.Линдэндорж, “Төрийн онол”, УБ, 1997 он, 33-р тал

## МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ

**Д.Мөнхбүрэн, “Глоб Интернэшнл” ТББ-ийн гүйцэтгэх захирал**

Монгол Улсын Үндсэн хуулиар “Иргэн төр, засгийн газрын мэдээллийг олж авах чадвартай байх” ардчиллын үндсэн зарчмын нэгийг бүрэн баталгаажуулжээ. Энэхүү зарчим үйлчилснээр иргэн өөрийн төлөөлөл болох төрийн түшээ, төр, засгийн байгууллага, түүний албан тушаалтнаас өөрийн эрх ашигт хамаатай аливаа мэдээлэл авахыг шаардах эрхтэй хэмээн ойлгож болно. Бид өөрсдөө ардчилсан сонгуулиар төр засгаа бүрдүүлж, тэдэнд өөрсдийн аз жаргалтай, сэтгэл хангалуун, элбэг баян амьдрах хамгийн таатай нөхцөл боломжийг бүрдүүлэх үүрэг ногдуулдаг. Учир нь тэд энэ бүхнийг амлаж гарч ирсэн, нөгөө талаар төр, засгийн газар, түүний бүтцийн байгууллагуудыг бид хувийнхаа халааснаас санхүүжүүлдэг. Иймээс төр засаг амласнаа хэр биелүүлж байна, бидний мөнгийг хэр үр ашигтай зарцуулж байна гэдэгт хяналт тавих хууль ёсны эрхтэй. Үүнийг “Олон нийтийн мэдэх эрх” гэж тодорхойлдог.

Мэдэх эрх нь хүний амьдрах эрхтэй салшгүй холбоотой. Хэрэв хүн нийгэмдээ болж буй үйл явдлыг мэдэхгүй, эсвэл удирдагчдынх нь үйл ажиллагаа нуугдмал байх аваас нийгмийн хөгжилд дорвитой хувь нэмэр оруулж чадахгүй, иргэдийн амьдрал ч дээшлэхгүй.

Мэдээллийг ардчиллын хүчилтөрөгч гэдэг. Ардчиллыг бэхжүүлэхэд мэдээллийн эрх чөлөө хамгийн чухал үүрэг гүйцэтгэнэ. Мэдээлэл нь зөвхөн хүмүүст хэрэгтэй зүйл төдийгүй, мөн шилдэг, шударга сайн засаглалын амин чухал салшгүй бүрэлдэхүүн хэсэг юм. Мэдээлэлгүйгээр төр засаг зөв шийдвэр гаргах боломжгүй. Харин нууцлаг байдал нь авлигыг тэжээн тэтгэх үндэс суурь болж, эрх мэдлээ буруугаар ашиглахад, мөн удирдлагын алдаатай үйл ажиллагаанд хүргэдэг байна. Мэдээлэл олж авах эрхийг баталгаажуулах нь төр засгийн үйл ажиллагаанд ч тустай. Нобелийн шагналт эдийн засагч Амартя Сений судалснаар ардчилсан засгийн газартай, харьцангуй чөлөөт хэвлэлтэй оронд хэзээ ч нийтийг хамарсан өлсгөлөн гарч байгаагүй гэдэг.

## **Мэдээлэлтэй байх нь:**

- Ардчилсан төр засгаа бүрдүүлэхэд нэр дэвшигчдийн талаар бодитой мэдээлэлтэй байж зөв хүнээ сонгож, зохих ёсоор сонгуульд саналаа өгөх;
- Олон нийтэд төр засгийн үйл ажиллагаанд хяналт тавих, хариуцлага тооцох боломж олгох;
- Мэдээллийг чөлөөтэй олж авснаар өөрийнхөө үзэл бодлыг чөлөөтэй илэрхийлж, өөрсдийн амьдралд тулгамдсан асуудлаар шийдвэр гаргахад оролцох, нөлөөлөх боломжтой болно.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 59 дүгээр чуулганаар “Мэдээллийн эрх чөлөө нь хүний үндсэн эрх бөгөөд бүх эрхэм эрх чөлөөний тулгуур чулуу мөн” гэж тунхагласан. Хэрэв мэдээллийн эрх чөлөө нь хүний үндсэн эрх юм бол бусад эрх нь түүнээс хамааралтай байх ба энэ эрхийг баталгаажуулахгүйгээр хүний эрхийг хамгаалах бүх систем зүй ёсоор ажиллаж чадахгүй нь тодорхой.

“Глоб Интернэшнл” ТББ 2001 оноос Мэдээллийн эрх чөлөөний мөн чанар, үзэл баримтлал, зарчмыг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр өргөн хүрээнд ажил хийсэн юм. Эхэн үедээ мэдээллийн эрх чөлөө гэдгийг олон нийт болон ялангуяа, эрх баригчид хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй юм уу, эсвэл шар хэвлэлтэй холбоотой мэтээр өрөөсгөл ойлгох нь түгээмэл байсан бол одоо мэдээлэл гэж юу юм бэ, хэвлэл мэдээллийн эрх чөлөөнөөс юугаараа ялгаатай юм гэдгийг хүмүүс ялгаж, салгаж ойлгодог болжээ. Өөрөөр хэлбэл, бид мэдээлэлгүй байснаараа өөрсдөө “хохирогч” болдог гэдгийг ухамсарлан, үүний төлөө идэвхитэй ярьж, бичиж, зарим нь тэмцэж эхэлсэн нь нэг талаар бидний ажлын үр дүнгийн илрэл хэмээн ойлгодог.

Мэдээллийг хайх, олж авах, хүлээн авах, түгээх гэсэн эрхийг багцаар нь мэдээллийн эрх чөлөө хэмээн томъёолдог. Мэдээлэл нээлттэй, чөлөөтэй, хүлээн авахад хялбар байх ёстой. Харин өнөөдөр Монгол Улсад иргэд төр засгийн болон хувийн аль ч байгууллагаас хүссэн мэдээллээ олж авах бололцоо тэр бүр алга байна. Энэ нь хэвлэл мэдээллийн байгууллага болон сэтгүүлчид олон нийтийн өмнө хүлээсэн "тэдний ашиг сонирхолд нийцсэн мэдээлэл түгээх" үүргээ биелүүлэхэд хамгийн их саад бэрхшээл учруулж байгаа юм.

Төр засгийн байгууллага, албан тушаалтны зарим нь өөрсдийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод байлгах сонирхол бага байгаа нь олон нийтийг тэдэнд эргэлзэхэд хүргэж байна. Тэд ч ард түмний төлөө албан ёсны мэдээллийг хадгалж байгаа гэж өөрсдийгөө үзэхээс илүүтэйгээр халдашгүй эрхтэйгээр тухайн мэдээллийг хамгаалагч гэж ойлгож, мэдээллийг өөрсдийн өмч мэт үздэг хандлага давамгайлж байна. Нөгөөтэйгүүр, Үндэсний аюулгүй байдал, иргэн хүний хувийн нууц, нийтийн эрх ашигт хохирол учруулахуйц мэдээллийн “халдашгүй” байдлыг түүнийг хамгаалах үүрэг бүхий этгээд хариуцах ёстой болохоос, бүх иргэдэд, үүнээс мэдээллийг олж авсан тухайн иргэнд хариуцлагыг нялзааж болохгүй билээ.

Дэлхий нийтийн чиг хандлагаар мэдээллийг хязгаарлалттай хүртэх, чөлөөтэй хүртэх гэсэн хоёр зарчим байдаг. Монгол Улсын эрх зүйн тогтолцооны хувьд хориглоогүй бүхнийг хүлээн зөвшөөрдөг зарчимд тулгуурладаг. Гэвч одоо мэдээллийн нээлттэй, ил тод байдлын хувьд хязгаарлалттай хүртэх зарчим түгээмэл үйлчилж байна. Иймд Мэдээллийн эрх чөлөөний хуулийг батлахдаа тодорхой, хор аюулын хэмжүүрээр ил болгож болохгүй нь тогтоогдсон, үүнээс бусад бүх мэдээллийг нээлттэй болгох зарчим баримтлах нь зүйтэй. Хууль нь сэтгэлгээний шинэ соёлыг бий болгож, төлөвшүүлэх ёстой. Төрийн байгууллагын мэдээлэл нээлттэй байх нь иргэдээс санал шүүмжлэл ихээр ирж, түүнийг нь зохистой амьдралд хэрэгжих бодитой шийдвэр гарах үндэслэл болно.

Мэдээллийн эрх чөлөөний хуультай болсноор ардчиллыг бэхжүүлж, төр, захиргааны байгууллагын үйл ажиллагааг нээлттэй, ил тод болгоно. Цаашилбал, иргэдийн үнэн зөв мэдээлэл олж авах боломж нэмэгдэж, иргэдэд мэдээлэл хайх, хүлээн авах хууль зүйн баталгаа бий болно. Мөн сонгогч сонгуульд мэдээлэлтэй оролцож зөв сонголт хийх

чадвартай болох төдийгүй иргэдийн нийгмийн амьдралд оролцох оролцоо нэмэгдэж, төрийн үйл ажиллагааг хянах, хариуцлага тооцох чадвартай болно.

Мэдээллийн эрх чөлөөний хууль төр, захиргааны байгууллагын буруу үйл ажиллагаа, авлигыг илрүүлэх, бууруулахад ч ач холбогдолтой. Мөн олон нийт санал бодлоо илэрхийлэх, хэлэлцүүлэг, маргаан явуулах, нөлөөлөх бололцоог олгоно. Мэдээлэл ил тод болсноор төр, засгийн байгууллага, нийтлэг үйлчилгээний болон баялаг хүртэгч хувийн байгууллагын иргэдэд үйлчлэх үүрэг сайжирна. Эцэст нь, энэ бүхний дүнд олон нийт, төр засгийн байгууллагын хоорондын итгэлцэл нэмэгдэнэ.

“Глоб Интернэшнл” ТББ 2001 оноос эхэлж төслийн олон судалгаа, шинжилгээний ажлын үр дүнд тулгуурлан “Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль”-ийн анхны хувилбараа боловсруулсан билээ. Хуулийн төслийг гадаад дотоодын хуульчид, мэргэжилтэн, шинжээчдээс зөвлөгөө авч боловсронгуй болгон, 2003 онд Хууль зүй дотоод хэргийн яаманд хүлээлгэн өгч, тус яамнаас байгуулагдсан ажлын хэсэгт ажилласан. Улмаар 2007 оны 05 дугаар сарын 03-ны өдөр буюу Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөр УИХ-ын нэр бүхий гишүүд мэдээллийн эрх чөлөөг баталгаажуулах хуулийн төслийг батлуулахаар УИХ-д өргөн барилаа.

Энэхүү хуулийн шинэ төслийг Хүний эрхийн түгээмэл тунхаглал зэрэг олон улсын эрх зүйн баримт бичиг, Англи улсын Лондон хотод байрлах “ХИХ зүйл” хэмээх төрийн бус байгууллагаас 2001 онд гаргасан Мэдээллийн эрх чөлөөний тухай загвар хуулийн үзэл санаа, “Глоб интернэшнл” ТББ-аас хийсэн “Ардчилал хөгжсөн болон ардчилалд шилжиж буй орнуудын хуулиудын харьцуулсан судалгаа” өмнө боловсруулан, Хууль зүй дотоод хэргийн яамнаас санаачлан Засгийн газрын хуралдаанаар оруулж байсан төслийн хувилбар зэрэг материалд тулгуурлан дахин боловсруулжээ.

Уг шинэчилсэн төсөлд нэлээд олон зарчмын шинжтэй зүйл орхигдож, хууль хэрэгжих механизм, процедурын шинжтэй зүйл заалтууд зохицуулалтгүй үлдэж болзошгүй байна. Тухайлбал, мэдээлэл авах хүсэлтээ зөвхөн бичгээр гаргах нь хязгаарлагдмал тул мэдээлэл авах олон хэлбэртэй адил зарчмаар цахим, биечлэн, утсаар гэх мэт хэлбэрийг оруулж, мөн чанарынхаа хувьд мэдээлэл байнга цаг хугацаагаар үнэлэгддэгийг харгалзан, шуурхай байх, үнэн бодитой байх, эргээд шүүх эрх мэдлийн байгууллагад нотлох баримтын хэмжээнд үнэлэгдэхүйц байх зэргийг тодотгох нь зүйтэй юм.

Аливаа мэдээлэл авах гэсэн иргэдээс зорилгоо тайлбарлахыг шаардах ёсгүй. Мэдээлэл өгснийхөө төлөө хэрээс хэтэрсэн төлбөр ногдуулж бас болохгүй. Мэдээллийн нууцлалын шалгуур, олон нийтийн ашиг сонирхол хоёрыг зэрэгцүүлэн тавиад, хэрэв олон нийтийн ашиг сонирхол нь давамгайлж байвал тухайн мэдээллийн ил тод, нээлттэй байлгах зарчмыг мөн хуульчилж өгөх нь чухал юм.

Мөн хэнд хадгалагдаж буй мэдээлэлд энэ нь хамааралтай вэ гэдэг асуулт гарч ирнэ. Мэдээж нэг талаас олон нийтийн өмчөөр болон татварын хөрөнгөөр санхүүжиж байгаа байгууллагуудын тухай мэдээлэл, нөгөө талаас нийт ард түмний өмч болох газар, түүний дор орших байгалийн баялаг, нийтийн баялгийн хуваарилалттай холбоотой, түүнд оролцож буй этгээдүүд, компаниудын мэдээлэл мөн олон нийтэд ил тод, нээлттэй байх ёстой. Өөрөөр хэлбэл, өмч, хөрөнгө, санхүүжилтийн хувьд олон нийтийн эрх ашгийг хөндөж байгаа бол тухайн байгууллагын мэдээлэл олон нийтэд ил тод, нээлттэй байх ёстой гэсэн үг юм.

Төр, түүний байгууллагаас заавал хэвлэн нийтлэх мэдээллийн жагсаалтыг өргөн хүрээтэй, нэг бүрчлэн дурдах, мөн нууцалж болохгүй мэдээллийн хүрээ, шалгуур, мэдэх эрхээ зөрчигдлөө гэж үзсэн хэн бүхэн гомдол гаргах, гомдлоо барагдуулах бодитой, үр дүнтэй механизмуудыг тусгаж өгөх нь зүйтэй юм.

Мэдээллийн эрх чөлөөний хууль бол гол суурь шинжтэй хууль болон үйлчлэхүйц хүчин чадалтай байх нь ардчилсан нийгэмд илүү тохиромжтой билээ. Уг хуулийн төслийг батлан гаргахдаа бусад хуулийг уялдуулан өөрчлөх, зарим хууль, түүний зүйл заалтыг өөрчлөх тухай хуулиудаа зэрэг батлан гаргасан үед хуулийн хэрэгжилтийг хангах, иргэдийн эрхийг баталгаажуулах бодит алхам болж чадна.



Иймээс мэдээлэлтэй ард түмэн л хүчирхэг байж, төрийн хэрэгт шууд оролцох эрхээ эдэлнэ. Мэдээллийн эрх чөлөөг баталгаажуулах нь төр засгаас олон түмнээ хүндэтгэсэн, иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх болон мэдээллийн эрх чөлөөг хангасан хууль ёсны, мөн зүй ёсны алхам болох билээ. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээллийн эрх чөлөөг хүндэтгэн хэрэгжүүлэх үүрэг нь зөвхөн хэвлэл мэдээллийн эрх зүйн үүрэг бус төр засгийн үндсэн үүрэг гэдгийг энд тэмдэглэе.

## **ЭГҮҮЛЭН ТАТАХ ЭРХ НЬ СОНГОХ ЭРХИЙН БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ БОЛОХ НЬ**

**Э.Ариунаа, ТЕГДС-ийн багш, магистр**

Сонгох эрх нь ардчилсан ёсны чухал институт бөгөөд ард түмний өөрийн хүсэл зоригоо илэрхийлэх болон улс төрийн амьдралд оролцох чухал хэлбэр юм.

Хөгжингүй, ардчилсан иргэний нийгэмд иргэд нийгмийн төлөө биш, харин нийгэм иргэдийн төлөө байж, эрх, эрх чөлөөг иргэдэд төр өгдөггүй, харин төрийн эрх, эрх чөлөөг иргэд тогтоодог, хүний эрхийн үндэс хууль болохгүй, харин хуулиудын үндэс хүний эрх болохоос гадна, өмч нийтийн сайн сайханд захирагдахгүй, харин нийтийн сайн сайхан нь хувь хүний өмчөөс урган гарч байх аж. Иргэний нийгмийн хөгжлийн ийм түвшин хүн төрөлхтөнд холын ирээдүйд хэвээр байна. Тийм ч учраас Монголын ард түмэн бид эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлон хөгжүүлэхийг зорьж буйгаа Үндсэн хуулиараа тунхагласан билээ<sup>16</sup>.

Монгол Улсын Үндсэн Хуулийн нэгдүгээр зүйлийн 2-т ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн хэмээн заасан байдаг.<sup>17</sup> Төрийн үйл ажиллагааны эдгээр зарчмууд нь өөр хоорондоо уялдаатай, хуваагдашгүй нэгдмэл байх ёстой билээ. Ардчилсан ёсны зарчим нь төрийн удирдлагад ард түмний оролцоог хангах гэсэн агуулгыг илэрхийлэх бөгөөд энэ нь зүгээр нэг тунхаглалын чанартай буюу зөвхөн хэлбэрийг харуулсан гоё үг биш байх ёстой гэдгийг мөн хуулийн гуравдугаар зүйлийн 1-д заасан Монгол Улсын засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна . . .<sup>18</sup> гэсэн заалт өгүүлж байна.

Ард түмэн бид бүгдээрээ хуран чуулж шийдвэрлэх боломжгүй олонлог бүхий тогтолцоонд төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих

<sup>16</sup> Н.Линдэндорж. Төрийн онол. УБ, 1997он, 72-р тал

<sup>17</sup> Монгол Улсын Үндсэн Хууль. Төрийн мэдээлэл. 1992 он, №1

<sup>18</sup> Монгол Улсын Үндсэн Хууль. Төрийн мэдээлэл. 1992 он, №1

төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ. Үндсэн хуулийн дээрх заалтууд нь төрийг удирдах эрхийг эдлэгч буюу энэ эрхийн эзэн, өмчлөгч нь Монголын ард түмэн та бид мөн гэдгийг хэлж байгаа нь тодорхой. Төрийг удирдах энэхүү эрхийг дагаж сонгуулийн эрх буюу сонгох, сонгогдох эрх зүй ёсоор гарч ирэх бөгөөд Үндсэн Хуулийн арванзургадугаар зүйлийн 9-д эдгээр эрхийг тодорхойлж өгсөн. Бид энд бичээд байгаа төрийг удирдах эрхээ Үндсэн хууль, Сонгуулийн тухай болон бусад хуулийн дагуу эдэлдэг. Харин төрийг удирдахад намайг, таныг төлөөлөх этгээдийг сонгох эрхээ бүрэн дүүрэн эдэлж чаддаг уу гэдэг асуудалд судлаач миний бие таны анхаарлыг хандуулах гэсэн юм.

1992 оноос хойш явагдсан Улсын их хурал, Ерөнхийлөгчийн сонгууль болон орон нутгийн сонгуульд оролцсон биз дээ, энэ чинь сонгох эрхээ эдэлж байгаа хэлбэр биш гэж үү гэж зарим хүн, бүр олон ч хүн байж магадгүй бодож болох юм. Тиймээ, бид Монгол Улсад ардчилсан Үндсэн хууль батлагдсан 1992 оноос хойш сонгуульд оролцож, өөрийгөө төлөөлж тодорхой түвшинд төрийн удирдах эрхийг эдлэх этгээдийг сонгож байсан гэдгийг би үгүйсгэх санаа агуулаагүй, гагцхүү сонгуульд оролцох гэдэг нь бидэнд байдаг сонгох эрхийн маань зөвхөн нэг хэсэг нь юм гэдгийг л хэлэхийг хүссэн юм.

Улсын их хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1-д Улсын их хурлын гишүүн бол төрийн эрх барих дээд байгууллагад сонгогдсон ард түмний элч бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална<sup>19</sup> хэмээн заасан нь дээр бичигдсэн зохицуулалтуудтай уялдаж Улсын их хурлын гишүүн нь ард түмний буюу сонгогчдын төлөөлөгч гэдэг логик утга зүй ёсоор гарч ирнэ. Түүнчлэн, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн<sup>20</sup> 8 дугаар зүйлийн 2-г “Нутгийн өөрөө удирдах ёс нь чөлөөт сонгуулиар сонгогдсон төлөөлөгчтэй, түүнд тайлагнадаг гүйцэтгэх байгууллагатай тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн асуудлыг иргэдийн ашиг сонирхолд нийцүүлэн хуулийн хүрээнд бие даан шийдвэрлэх эрх зүйн бодит чадвар юм”, Орон нутгийн хурлын сонгуулийн тухай хуулийн<sup>21</sup> 4 дүгээр зүйлийн 1-д “Орон нутгийн хурлын төлөөлөгчдийг Монгол Улсын иргэд нийтээрээ, чөлөөтэй шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж сонгоно”. Тэгвэл тэр төлөөлөгчид та бид төрийг удирдах эрхээ өгсөн биз дээ. Тиймээ, тэр эрхэм гишүүн төр барилцахад биечлэн оролцох эрхийг бурхнаас ч биш, Улсын Их Хурлаас ч биш, Үндсэн хуулийн цэцээс ч биш, шүүхээс ч биш гагцхүү Монголын ард түмэн та биднээс авч, биднийг төлөөлж тэнд ажиллаж байгаа, үүнийх нь төлөө ч та бид тэдэнд цалин хөлс төлдөг, бидний өмнөөс бидний төлөө төр барилцах ажилд нь хэн нэгэн этгээд хууль бусаар битгий саад болоосой хэмээн хангамж эдлүүлж, халдашгүй дархан байлгадаг.

Бид тэдэнд өөрт байдаг эрхээ шилжүүлсэн, өөрөөр хэлбэл төрийг удирдахад оролцоход өөрийгөө төлөөлөх итгэмжлэлийг энэ төлөөлөгч гишүүдэд өгсөн.

Тэгвэл **Төлөөлөл** гэж юу гэсэн ойлголт вэ? Хууль зүйн шинжлэх ухааны доктор /Ph/, профессор Т.Мөнхжаргал “төлөөлөл гэдэг нь нэг талаар иргэний эрх зүйн харилцааг үүсгэх, өөрчлөх, дуусгавар болгоход чиглэсэн үйлдэл, нөгөө талаас субъектүүд бие биедээ итгэх итгэл болон эдийн засаг, эрх зүйн туслалцаа үзүүлж буй хэлбэр юм. Төлөөлөгч нь төлөөлүүлэгчийн эрх ашгийн төлөө, түүний нэрийн өмнөөс гуравдагч этгээдтэй хэлцэл хийх болон хууль зүйн бусад үйлдэл хийх явцад үүсдэг зохион байгуулалт, эрх зүйн харилцааны нэг өвөрмөц төрөл болно”<sup>22</sup>, хэмээн тодорхойлсон бол Тагнуулын ерөнхий газрын сээд сургуулийн тэнхимийн эрхлэгч, дэд профессор Д. Бат-Өлзий “нэг этгээд буюу төлөөлөгчийн зүгээс олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд төлөөлүүлж байгаа этгээдийн эрх, ашиг сонирхлын төлөө түүний нэрийн өмнөөс хэлцэл буюу бусад хууль зүйн үйлдэл хийх явдлыг

<sup>19</sup> УИХ-ын гишүүний эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, 2000 он, №

<sup>20</sup> Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль. Төрийн мэдээлэл сэтгүүл, 2007 он, №2

<sup>21</sup> Орон нутгийн сонгуулийн тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, 2007 он, №7

<sup>22</sup> Т.Мөнхжаргал “Иргэний эрх зүй” /ерөнхий анги/. УБ. 1997он, 88-р тал

ойлгоно”<sup>23</sup> гэсэн бол ОХУ-ын эрдэмтэн Н.Д.Егоровын бүтээлд “төлөөлөл гэдэг нь төлөөлүүлэгчийн өгсөн бүрэн эрхийн хүрээнд, түүний эрх, ашиг сонирхлын төлөө, түүний нэрийн өмнөөс хэлцэл болон бусад хууль зүйн үйлдэл хийх явдлыг ойлгоно”<sup>24</sup>, мөн төлөөлөлтэй холбоотой нийтлэг эрх зүйн зохицуулалтыг агуулсан Иргэний хуулийн<sup>25</sup> 63 дугаар зүйлийн 3-т “Төлөөлөгч нь бүрэн эрхээ шударгаар, төлөөлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд нийцүүлэн хэрэгжүүлэх үүрэгтэй” хэмээн заасан нь төлөөлөгчийн бүрэн эрх зөвхөн төлөөлүүлж байгаа этгээдээс ирнэ, төлөөллийн үндсэн зорилго нь төлөөлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд нийцүүлэн хэлцэл, болон бусад хууль ёсны үйлдэл хийхэд оршино гэсэн үг билээ.

Төлөөлөгчид түүний бүрэн эрх үүсэх үндэслэлийг Иргэний хууль, юуны өмнө төлөөлүүлэгчийн хүсэл зоригийн илэрхийлэл болон хуульд тусгайлан заасан хууль зүйн фактуудтай холбосон. Төлөөлөгчийн бүрэн эрхийн хэмжээ, хязгаар, шинж болон тэдгээрийг хэрэгжүүлэх нөхцөл зэрэг нь төлөөллийн үндэс болж буй хууль зүйн фактуудаас хамаардаг<sup>26</sup>.

Төлөөллийг:

- а/ хууль ёсны
- б/ захиргааны шийдвэрт,
- в/ гэрээнд үндэслэсэн гэж ангилах

бөгөөд захиргааны шийдвэрт болон гэрээнд үндэслэсэн төлөөлөл нь итгэмжлэлийн үндсэн дээр үүснэ.

Хуульд үндэслэгдсэн төлөөлөл нь хууль ёсны гэж нэрлэгддэг бөгөөд бага насны ба насанд хүрээгүй хүмүүсийн хувьд эцэг, эх нь буюу асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь тэднийг иргэний эрх зүйн харилцаанд төлөөлнө.

Захиргааны шийдвэрт үндэслэсэн төлөөллийн үед төлөөлөгч нь төлөөлүүлэгчийнхээ гаргасан захиргааны шийдвэрийн дагуу үйл ажиллагаа явуулах ба тэдгээр этгээдүүд хоорондоо захиргааны, хөдөлмөрийн, албаны зэрэг нэг нь нөгөөдөө захирагдахтай холбогдсон харилцаанд оршино.

Гэрээнд үндэслэсэн төлөөлөл нь сайн дурын үндсэнд үүсэх буюу төлөөлүүлэгчийн хүсэл зоригийн дагуу үүсэх ба төлөөлөгчөө өөрөө сонгож, бүрэн эрхийг нь тодорхойлно.Түүнчлэн, төлөөлөгчийн зөвшөөрөл хэрэгтэй байдаг. Иймд тэдний хооронд гэрээ байгуулагдана<sup>27</sup>.

Сонгуульд өөрийн хүсэл зоригийн дагуу нэр дэвшсэн этгээдүүдээс өөрийгөө төлөөлүүлэх хүнээ сонгож саналаа өгсний үндсэн дээр сонгогчдын олонхийн саналыг авсан этгээд сонгогддог нь яах аргагүй гэрээнд үндэслэсэн төлөөллийн хэлбэр болно.

Төлөөлөл нь зайлшгүй тодорхой зорилго, мөн хугацаатай байна. Энэ 2 нөхцлийн аль нэг үгүй болбол төлөөлөл дуусгавар болно. Бидний тохиолдолд сонгогдож буй этгээд нь биднийг төлөөлж төрийг удирдахад оролцох зорилготой ба хуульд заасан хугацаатай сонгогддог. Иргэний хуулийн<sup>28</sup> 67 дугаар зүйлийн 2-т төлөөлөл дуусгавар болох дараах үндэслэлүүдийг тодорхойлсон байна.

Үүнд:

- төлөөлөгч бүрэн эрхээсээ татгалзсан;
- төлөөлүүлэгч нь өөрийн олгосон бүрэн эрхийг хүчингүй болгосон;
- хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол төлөөлүүлэгч буюу төлөөлөгч нас барсан, эсхүл эрх зүйн бүрэн чадамжгүй болсон, итгэмжлэл олгосон хуулийн этгээдийн үйл ажиллагаа дуусгавар болсон,;

<sup>23</sup> Д.Бат-Слзий “Иргэний эрх зүй”, УБ, 2005 он, х 91-р тал

<sup>24</sup> Н.Д.Егоров и др.”Гражданское право” /часть 1/ Москва. 2001г. стр.268

<sup>25</sup> Иргэний хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, 2002 он, № 7

<sup>26</sup> Д. Бат-Слзий “Иргэний эрх зүй”, /тэргийн дэвтэр/ 2005 он, 93-р тал

<sup>27</sup> Д. Бат-Слзий “Иргэний эрх зүй”, /тэргийн дэвтэр/ 2005 он, 93-р тал

<sup>28</sup> Иргэний хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, 2002 он, № 7

- бүрэн эрхийг хэрэгжүүлсэн;
- бүрэн эрхийг хэрэгжүүлэх хугацаа дууссан;
- хуулиар тогтоосон төлөөлүүлэх үндэслэл дуусгавар болсон бол хуульд заасан журмаар.

Түүнчлэн, мөн зүйлийн 3-т “Хэдийд ч төлөөлүүлэгч итгэмжлэлээ хүчингүй болгох, төлөөлөгч итгэмжлэлээсээ татгалзах эрхтэй. Энэ эрхийг эдлэхгүй гэж тохирсон хэлцэл хүчин төгөлдөр бус байна” хэмээсэн нь төлөөлүүлэх эрхэд зөвхөн төлөөлүүлэх эрх төдийгүй төлөөлүүлэхээс татгалзах эрх хамаардгийг харуулж байна.

Төрийг удирдахад оролцох өөрийнхөө эрхийг бусдад өгч өөрийгөө төлөөлүүлж байгаа бидэнд итгэлийг минь дааж ажиллаж чадахгүй байгаа буюу төлөөллийн зорилгыг умартан байгаа төлөөлөгчөөс буюу эрхэм гишүүдээс өөрийнхөө эрхийг буцааж авах эрх зайлшгүй байх ёстой бөгөөд энэ нь сонгох эрхийн маань салшгүй бүрэлдэхүүн хэсэг яах аргагүй мөн юм.

Улсын их хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулиар<sup>29</sup> Улсын их хурлын гишүүнийг:

- ерөнхийлөгчөөр сонгогдсон, биеийн эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсноос чөлөөлж өгөхийг хүсч гишүүн өөрөө өргөдөл гаргаснаар чөлөөлнө;
- эгүүлэн татах үндэслэлтэй гэж Үндсэн хуулийн цэц дүгнэлт гаргасан бол Улсын Их Хурал гишүүнийг эгүүлэн татах эсэх асуудлыг шийдвэрлэнэ;
- гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоосон бол Улсын их хурал гишүүнээс нь эгүүлэн татна хэмээн заасан.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар<sup>30</sup> аймаг, нийслэл сум дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчийн бүрэн эрх нас барсан, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар чөлөөлөгдөх хүсэлтээ өөрөө гаргасан, хүндээр өвчилсний улмаас цаашид бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон тухай эмнэлгийн дүгнэлт гарсан, гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор батлагдсан, тухайн орон нутгаас шилжсэн тохиолдолд хугацаанаас өмнө дуусгавар болохоор заажээ.

Дээр дурдсан үндэслэлүүдээс нэг нь ч эрхийг нь өгсөн этгээд буюу Монголын ард түмэн бид эрхээ буцааж авах боломжийг өгүүлээгүй байна.

**Гэтэл бид төрийг удирдахад оролцох эрхээ төлөөлөгчид бүрмөсөн шилжүүлж өгөөгүй шүү дээ.**

Эсвэл нэгэнт сонгосон юм чинь бусад асуудал чамд хамаагүй гэж байгаа юм уу? Итгэмжлэлийг минь авчихаад миний нэрийн өмнөөс юу ч хийсэн болно, цаашид юу хийх нь надад хамаагүй гэж үү?

Нэгэнт надаас, чамаас төрийг удирдах эрхийг минь авч, намайг, чамайг төлөөлж байгаа юм чинь хэрхэн үүргээ гүйцэтгэж байгаад нь хяналт тавих эрх төлөөлүүлэгчид байгаа, итгэл дааж ажиллаж чадахгүй байгаа этгээдийг хүссэн үедээ солих эрх надад бас байгаа.

Ямар ч зүйлийн бүтцэд байдаг элементүүд бүгд бүрэлдэж байж тухайн зүйл бүрэн бүтэн болдог. Ялангуяа, энэ ойлголт хууль эрх зүйд маш чухал үүргийг гүйцэтгэдэг. Тийм болохоор сонгох эрхийн маань бүрэлдэхүүн эрхүүд болох сонгох эрх болон сонгосон этгээдээ эгүүлэн татах эрхийн аль нэг л байхгүй буюу аль нэгийг нь л эдэлж чадахгүй бол бид сонгох эрхээ эдэлж чадахгүй байна гэсэн үг билээ. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд тодорхойлогдсон, ардчилсан төрт нийгмийн салшгүй нэг элемент болох сонгох эрх маань зөрчигдөж байна гэж үзэж байна.

<sup>29</sup> Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хууль. Төрийн мэдээлэл сэтгүүл. №

<sup>30</sup> Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, 2007 он, №2

**Энэ бүхнээс дүгнэвэл:**

1. Сонгосон этгээдээ эгүүлэн татах эрх нь сонгох эрхийн бүрэлдэхүүн мөн.
2. Монголын ард түмэн бидэнд сонгох эрхээ бүрэн эдлэх эрх зүйн орчин байхгүй байна.

**Санал:**

Монгол Улсын Үндсэн хуульд заасан төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх үүргээ<sup>31</sup> биелүүлж итгэл алдсан төлөөлөгчөөс итгэмжлэлээ буцаан авах төлөөлүүлэгчийн эрх буюу ард түмнийхээ сонгох эрхийн бүрэлдэхүүн хэсэг болсон сонгосон этгээдээ өөрөө эгүүлэн татах эрх, түүнийг хэрэгжүүлэх журмыг хуульчилж өгөх саналыг дэвшүүлж байна.

## **ХҮҮХДИЙН ЭЛЧ БУЮУ ХҮҮХДИЙН ОМБУДСМЕН**

### **Ц. Түвшинтөгс Монгол Улсын гавьяат багш, Хүүхэд, гэр бүл судлаач**

#### **Омбудсмен гэж хэн бэ?**

“Омбудсмен” гэдэг нь англи хэлнээ орж ирсэн Скандинав гаралтай цөөн үгийн нэг юм. “Элч-төлөөлөгч” гэсэн утгатай бөгөөд анх “эзэн хааны элч” гэсэн утгатай үүсчээ. Сүүлдээ “Омбудсмен” нь тодорхой бүлэг болон хэсгийн гишүүдийн эрх ашиг, сонирхол хэрэгцээг илэрхийлж хамгаалсан хүн буюу байгууллага гэсэн утгатай болж агуулга нь баяжжээ.

Өнөө үед “Омбудсмен” нь дэлхийн олон оронд нийт иргэдийн эрх ашгийг хамгаалж, олон нийтийн хяналт тавих үүрэгтэйгээр ажилладаг болов. Анхны омбудсмен нь засаг захиргааны үйл ажиллагаанд төр захиргааны эрх мэдлийг урвуулан ашиглах явдалтай тэмцэх, иргэдийн нийтлэг болон хувийн эрх ашиг хамгаалах үүрэгтэйгээр 1809 онд Швед, 1954 онд Дани, 1962 онд Норвеги зэрэг улсуудад ажиллаж эхэлсэн бол зөвхөн хүүхдийн омбудсмен гэхэд л одоо дэлхийн 72 оронд ажиллаж байна. Дэлхийн маш олон оронд “Парламентийн омбудсмен”, “Зэвсэгт хүчний омбудсмен”, “Хүйсийн тэгш эрхийн омбудсмен”, “Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах омбудсмен” гэх мэтээр төрөлжин ажилладаг.

Хүүхдийн эрхийн тухай конвенц 1989 онд батлагдсанаас хойш олон оронд хүүхдийн омбудсмен ажилладаг болов. Хүүхэд эдийн засаг болон улс төрийн эрх мэдэл байхгүй, өөрийн санаа бодлоо илэрхийлэх боломж хязгаарлагдмал учраас тэдний эрх ашиг, сонирхол хэрэгцээг хамгаалах биеэ даасан байгууллага юм уу төлөөний хүн зайлшгүй шаардагддаг.

Олон улсын практик амьдралд хүүхдийн омбудсмен нь:

-Хүүхдийн санал гомдол гарсан, эрх нь зөрчигдсөн нөхцөлд шуурхай арга хэмжээ авах ба санал боловсруулах;

<sup>31</sup> Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, 1992 он, №2

-Хүүхдийн асуудлаар төрийн бодлого, хууль тогтоомж, практик үйл ажиллагаанд нөлөөлөх боловч өөрөө төр-захиргааны байгууллагаас ангид ажиллах;  
-Хүүхдийн эрх, түүний хэрэгжилтийг олон нийтэд сурталчлах ба энэ талаар мэдээлэл цуглуулах, төр олон нийтийг мэдээллээр хангах;  
-Хүүхдийн эрхийн чиглэлээр ажилладаг аливаа байгууллагын үйл ажиллагаанд олон нийт, ялангуяа хүүхдийг төлөөлж хяналт тавих гэх мэт олон чиглэлийг барьж ажилладаг ажээ.

НҮБ-аас гаргасан Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 43 дугаар зүйлд уг конвенцид оролцогч улсууд хүлээсэн үүргээ хэрхэн хэрэгжүүлж, үндэснийхээ хүрээнд хүүхдийн эрхийг хэрхэн хангаж байгааг хэлэлцэж, санал дүгнэлт гарган, зөвлөлгөө өгч байх зорилгоор Хүүхдийн Эрхийн асуудал эрхэлсэн хороо байгуулах тухай заасан билээ.

Энэхүү НҮБ-ын Хүүхдийн эрхийн олон улсын хороо нь дэлхийн дахинаа хүүхдийн эрхийн хэрэгжилтээр ажилладаг “Олон улсын омбудсмен”-ий үүрэг гүйцэтгэдэг гэж хэлж болно.Тус хороо Хүүхдийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилтээр Монгол Улсын тайлан илтгэлийг 1996 онд анх удаа хэлэлцээд үндэсний хүрээнд хүүхдийн омбудсмен ажиллуулахыг зөвлөсөн билээ.

### **Монголын хүүхдийн омбудсмен**

Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 245 дугаар тогтоолоор баталсан “Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр”-ийн 1.2.6-д “**Хүүхдийн эрхийн хэрэгжилтэд хяналт тавих омбудсмен ажиллуулах асуудлыг судлах**” гэж заажээ. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 197 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Хүүхдийн төлөө үндэсний газрын стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-ийн 11 дүгээр зүйлд “Орон нутгийн хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагаас сонгогдсон, эсхүл томилогдсон хүн баг, хорооны түвшинд Хүүхдийн элч, хүүхдийн нөхрөөр ажиллана, Хүүхдийн элч, эсхүл хүүхдийн нөхөр орон нутгийн хуралд хүүхдийг төлөөлөн оролцоно гэж хүүхдийн эрх ашгийг илэрхийлж, тэднийг төлөөлөх хүний тухай тусгагдсан байна. Уг заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Хүний эрхийн үндэсний комисс, Хүүхдийн төлөө үндэсний газрын даргын 2005 оны 07/47 хамтарсан тушаалаар “Хүүхдийн элч” сонгон ажиллуулах журмыг баталсан байна.

Уг дүрэмд зааснаар “Хүүхдийн элч” нь Хүүхдийн эрхийн болон Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Хүүхдийн эрхийн тухай конвенц, Монгол Улсын Үндсэн хууль, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай болон Монгол Улсын хүний эрхийн эндэсний эомиссын тухай хууль, бусад хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.

“Хүүхдийн элч” нь шударга ёсыг эрхэмлэж, зөвхөн хүүхдийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримтлан,аливаа нам, улс төрийн хүчний нөлөөллөөс ангид бие даасан үйл ажиллагаа явуулахдаа ямагт хүүхэд, өсвөр үеийнхний санал бодол, хүсэл эрмэлзэл, эрх ашгийг илэрхийлж ил тод, чөлөөтэй ажиллах зарчмыг баримтална.

Орон нутгийн хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагын нэгдсэн чуулганаас “Хүүхдийн элч”-ийг гурван жилийн хугацаагаар ил, нэр дэвшүүлж сонгоно. Хүүхдүүд өөрсдөө хамгийн сайн таньдаг, олон нийтийн дунд нэр хүндтэй, хүүхдийн эрхийг хангах, хамгаалах чиглэлээр ажиллах зохих мэдлэг, чадвар, дадлага, туршлагатай, хүүхдэд хайртай хүнээ шилж сонгох бүрэн боломжтой юм. Уг дүрэмд зааснаар засаг захиргааны анхан шатны нэгж /сум ба хүн ам суурьшсан тосгон, аймгийн төвийн баг, нийслэлийн хороо/-д нэг хүн “Хүүхдийн элч”-ээр ажиллана.

Хүүхдүүдийн сонгосон “Хүүхдийн элч”-ийг баг, хороо, сумын нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Хүний эрхийн орон тооны бус зөвлөл, Хүүхдийн төлөө зөвлөлийн шийдвэрээр олон нийтэд зарлаж, “Андгай” өргүүлэн, “Батламж” гардуулснаар бүрэн эрхийг нь албан ёсоор баталгаажуулна.

“Хүүхдийн элч”-ийн **Андгай:**

\_\_\_\_\_ овогтой \_\_\_\_\_

Миний бие өөрийн нутаг дэвсгэрийн бүх хүүхэд багачуудын дотны, үнэнч анд нь байж, тэдний хүсэл зорилго итгэл найдварыг биелүүлэхийн төлөө өөрийгөө дайчилж, “Хүүхдийн элч”-ийн нэр хүндийг нандигнан, өндөрт өргөж ажиллахаа Андгайлж байна.

“Хүүхдийн элч” дараах бүрэн эрхийг хэрэгжүүлдэг.

Үүнд :

- Тухайн нутаг дэвсгэрт хүүхдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр явуулж буй бүх үйл ажиллагаанд хүүхдийн нэрийн өмнөөс үнэлгээ дүгнэлт өгөх;
- Хүүхэд багачуудын өмнө тулгамдсан асуудал болон тэдний эрэлт хэрэгцээг бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдад уламжлан, хэрэгжүүлэхэд нь зөвлөх;
- Харьяа нутаг дэвсгэрт хүүхдийн эрхийг хангах, хамгаалах талаар гарсан мэдээлэл, санал хүсэлт, өргөдөл гомдлыг хүлээн авч холбогдох байгууллага, албан тушаалтанд уламжилж шийдвэрлүүлэх;
- Хүүхдэд нийгмийн үйлчилгээ үзүүлдэг өмчийн бүх хэлбэрийн байгууллага /цэцэрлэг, сургууль, зуслан, эмнэлэг, халамжийн төв, асрамжийн газар г.м/, албан тушаалтан, гэр бүл, хувь хүмүүст үнэн мэдээлэл өгч, хүүхдийн эрхийн үнэлэмжийг дээшлүүлэх;
- Хүүхдийн эрхийг зөрчсөн тохиолдол ба үйлдлийг даамжруулсан буюу хайхрамжгүй хандсан байгууллага, албан тушаалтан, хувь хүмүүсийг дээд шатны байгууллага, албан тушаалтанд мэдээлж, тухайн асуудлаар нутгийн удирдлагын болон хууль хяналт, хүний эрхийн байгууллагын дүгнэлт шийдвэр гаргуулах г.м болно.
- “Хүүхдийн элч” нь тухайн нутаг дэвсгэрийн хүүхэд, өсвөр үеийнхний эрх ашгийг бүрэн илэрхийлж, тэдэнд туслах, зөвлөх үүрэг гүйцэтгэхийн дээр өөрөө бие даан эцсийн шийдвэр гаргах, няцаалт өгөх шаардлагагүй юм. Тэрээр хүүхдийн эрхийн асуудлаар мэдээлэл цуглуулах, боловсруулах, санал дүгнэлт гаргахдаа “Шаардах хуудас”, “Зөвлөмж”, “Уриалга” зэрэг баримт бичиг гаргана. “Хүүхдийн элч”-ийн үйл ажиллагаанд холбогдох аливаа бичиг баримт нь орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, түүний дэргэдэх Хүний эрхийн орон тооны бус зөвлөлийн албан хэрэгт хадгалагдана. Иймд нутгийн өөрийн удирдлагын байгууллага, Засаг дарга нь харьяат нутаг дэвсгэртээ “Хүүхдийн элч” ажиллах нөхцлийг бүрэн хангаж, /шуудан холбоо, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, бичиг хэрэг, байр, унаа, томилолт г.м/ шаардагдах санхүүгийн болон бусад дэмжлэгийг төсөв төлөвлөгөөндөө тусгаж шийдвэрлэх ёстой.

### **Туршлага, сургамж:**

Богино хугацаанд олонхи аймаг, сум, дүүрэг, хороо, багт “Хүүхдийн элч”-ийг сонгон ажиллуулж эхлэв.

“Хүүхдийн элч” ажиллуулах талаар аймгуудын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид, Хүүхдийн төлөө зөвлөл холбогдох шийдвэр гаргаж, шинээр сонгогдсон “Хүүхдийн элч” нарт дэмжлэг туслалцаа ч үзүүлдэг болов. Орхон, Дундговь, Ховд, Өвөрхангай, Дорнод, Увс зэрэг олон аймагт “Хүүхдийн элч” нарын сургалт семинар хийж, тэднийг сургаж дадлагажуулах, мэдээллээр хангах талаар зохих арга хэмжээ авч байна.

“Хүүхдийн элч”-ээр ихэвчлэн олон жил багшилсан, төр засгийн хариуцлагатай алба хашиж байсан, одоо төрийн бус байгууллагад сонгуульт үүрэг хүлээсэн, дадлага туршлагатай хүмүүс, ялангуяа хүүхдийн хөдөлгөөний ахмад зүтгэлтэн, нийгмийн идэвх зүтгэл, ухамсар сайтай залуу хүмүүсийг сонгосон нь зөв зүйтэй эхлэл юм.

“Хүүхдийн элч”-ээр хоёр удаа сонгогдвол “Хүүхдийн эрхийн итгэмжит элч”, гурав ба түүнээс олон удаа сонгогдвол “Хүүхдийн эрхийн хүндэт элч”-ээр өргөмжлөгдөх учир энэ алба нь нэр төрийн хэрэг төдийгүй нутаг газартаа олны тус, ирээдүйн төлөө хүч чармайлт, идэвх зүтгэлээ зориулах хариуцлагатай, сэтгэл зүрхний алба юм.

“Хүүхдийн элч”-ийг Хүний эрхийн үндэсний комисс, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл, тэдгээрийн орон нутгийн салбар мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах учиртай.

Гэтэл шинэ тутам ажиллаж эхэлсэн “Хүүхдийн элч”-ийг жинхэнэ утгаар нь эрчимтэй, нэр хүндтэй ажиллуулах талаар бага анхаарч байгаад дүгнэлт хийх нь зүйтэй байна.

**Ардчилал-18 жил  
( эссе )**

**ЦАСАН БӨМБӨЛГИЙН АРДЧИЛАЛ БУЮУ  
МОНГОЛЧЛОГДСОН АРДЧИЛАЛ ДАХЬ ХҮНИЙ ЭРХ**

**Б.Дуламсүрэн, МУИС-ын Хууль  
зүйн сургуулийн оюутан**

Монгол Улсын Үндсэн хуулийн арван дөрөвдүгээр зүйлийн 2-д :

“Хүнийг үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно...”

Зун юмдаг, гадуур явж хэрэгцээтэй гэх зүйлсээ цуглуулчихаад микронд /микро автобус/ сууж байтал, гаднаас нэг өвгөн суух санаатай чиглэн ирж харагдсан юм. Гэтэл өвгөнийг үзэнгүүтээ кондуктор нь хаалгаа тас хийтэл хаагаад, ёстой л оросын үлгэр дээр гардаг үхэшгүй мөнхийн Кашейгаас айн үргэж буй хүн шиг “хачирхалтай” загнаж билээ. Эсвэл энэ нь охид бүсгүйчүүдийн хэллэг болсон “мода” гэгч нь энэ юм болов уу? (Бүү мэд!) Хүн хүнээсээ үргэдэг, тэр дундаа настайчуулаасаа үргэдэг “мода” дэлхийн аль ч улсад байгаагүй санагдах юм. (Социализмын гэгдэх үед ч гэсэн)

Монголчууд тэгш эрх эдэлж, чин шударгаар шүүлгэн, сайн сайхан бүхнийг хүртэж, эрх чөлөөг амтлах гэж ардчилалыг сонгосон. Уг нь бид ардчиллын амин сүнс болсон “хүний эрх”-ийг хууль, дүрэм, журамдаа нягт нямбай тусгаж өгсөн байх юм. Гэтэл өнөөдрийн ардчилалын нэрэн доорхи “Монголын нийгэм нь ардчилагдаад байна уу, ардчилал нь монголчлогдоод байна уу?” (Юм бүхнийг монголчилж чаддагаараа бахархдаг бид хүсэж олсон ардчиллынхаа амин сүнсийг гээгээд байгаагаа ойлгож байгаа болов уу ?)

Автобусны кондукторын зан үйлдлээс авахуулаад төрийн гэх тодотголтой албан байгууллага, . . . номын сан, үйлчилгээний газар болон гудамж талбайд алхах хэн бүхний дунд түүнчлэн, нарсан хаалганы ард хүний эрх ямагт хөндөгдөж, зөрчигдөөд байхад тэр нь нэгэн хэвийн үзэгдэл мэт хэнийг ч үл цочрооно.



**“Ойчиж байгаа хүнийг их хүчтэй гэмтээхгүйн тулд бид ердөө дуу алдан халаглаж чадах юм гэж үү?”**

**Жиль Делёз<sup>1</sup>**

Надад л хамаатай биш бол, “падгүй” гэсэн дүрэм Монголын ардчилсан гэх нийгэмд үйлчлээд байгаа юм биш үү? (Бодууштай л юм)  
Нөгөө төлөөллөөр сонгогдоод гарсан эрх баригчдад, энэ бас л “падгүй” юу? (Асуух л асуулт)

**Олон хүн нэг хүнийг зодож байвал “Хятад” кино  
Олон хүнтэй нэг хүн зодолдож байвал “Солонгос” кино  
Нэг хүн олон хүнд зодуулж байвал “Монгол” кино**

(Наргианы 80 хувь үнэн гэж)

Хүн гараа зүссэн үедээ, цусаа урсгаад л хээв нэг: Өө надад 5 литр цус байгаа юм чинь хэдхэн “мг” цус алдахад ямар хамаа байх вэ гэж ханддаггүй нь лавтай. Уул нь ардчиллын зарчим үүнтэй эгээ л адилхан юмсан.

**-Английн систем: “Болохгүйгээс бусад бүгдийг болно”  
-Герман систем: “Болно” гэдгээс өөр юу ч болохгүй  
-Франц систем: “Болохгүй ч болно. Бүгд болно”  
-Орос систем: “Юу ч болохгүй”, “Болно гэснийг ч болохгүй”  
-Монгол систем: “Болно... болохгүй...та хэн бэ?” гэдгээс . . . хамаарна.<sup>2</sup>**

Монгол Улсад хүний эрх хангагдах гол үндэс нь “Та хэн бэ?” гэдгээс шалтгаалдаг болсон гээд хэлчихвэл нэг их буруудахгүй болов уу.

**“Бүдүүлэг заваан хүн л дэвшүүлсэн бол, олзуурхам сайхан санаа ч үнэ цэнэгүй”  
Освольд Шпенглер<sup>3</sup>**

Төр гэсэн хийсвэр ойлголтоор бүрхэвч хийчихээд сууж буй хэдхэн хүмүүсийн гарт эрх мэдэл төвлөрчихөөд нөгөө цөөнхи гэх хүмүүсийн дуу хоолойг боон дарж, улс төрийн бүлэглэлээр нь ялгаварлан гадуурхаж, бусдын эрхэд халдана.

**Хүмүүнлэг иргэний нийгмийг “бүтээнэ”** хэмээн онолын хувьд алдаатай үгсийг хэрэглэж байхдаа ард түмнээс шилжүүлж авсан эрхээ 100 хувь эдэлж, 0 хувийн үүрэг хүлээгээд байх шиг.

Бидэнд үйлчлэх гэж сонгогдсон юмуу, эсвэл бидэнд ноёрхох гэж оршоод ч байгаа юм уу? (Ёстой бурхан багш л мэдэх байх ) Угтаа бол “үйлчилнэ” гэж амласан санагдах юм. Хэрвээ би буруу сонсоогүй бол (Миний чих сонсгол сайтай л даа)

**“Эрх баригчид дуулгавартай хүмүүсийг үнэлж, нөлөөнд нь автамхай хүмүүст итгэдэг”**

**Карл Раймунд Поппер<sup>4</sup>**

Хэрэв би андуураагүй бол Монгол Улсын Үндсэн хуулийн арванзургадугаар зүйлийн 17-д: **“Иргэн . . . мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. . .”** гэж цагаан дээр хараар бичсэн байгаа. Иргэдийн нүдийг дарж, хааж боочихоод чихэнд нь худал зүйл шивнэн мэдэх мэдээлэлтэй байх эрхээр нь хангачихлаа гэж үзэж байгаа төр бол эгээ л нүдээ дарчихаад бусдаас нуугдаж чадсан гэж өөртөө итгүүлэх бяцхан жаалтай адил юм.

Оюутан миний хувьд ч гэсэн төрийн байгууллага, албан тушаалтнаас өөрт хэрэгцээтэй мэдээ мэдээлэл, лавлагаа авна гэдэг “харганы ноос түүж эсгий хийх” дайны юм болно.

Нүсэр шат дамжлагыг дамжин арайхийж уулзах зөвшөөрөл автал цайны цаг, хуралтай гэх мэтийн “жижүүрийн хэдхэн үг”-ийг жижүүрээрээ хэлүүлээд халгаахгүй. Тэнгэрийн умдаг

атгах шиг тэр даргын улаан нүүрийг арайхийн хартал хөл бөмбөг шиг өөр нэгэн албан тушаалтны нэр хаягийг зааж өгчихөөд ул мөргүй арилан одно.

**Ингэж хөл бөмбөг шиг хэдэн тийш өшигчүүлэн үгээ барж үсээ үгтээн, ширэн нүүрлэж зогсоход минь чамд үйлчилдэг чавганц нар биш ээ гээд чадал чинь хүрвэл “хөлөө хүрэх газар очиж заргалдаарай гээд хэлээ гаргана”. Уул нь бидний төлсөн татвараар санхүүжиж бидэнд үйлчлэх ёстой биш гэж үү?**<sup>5</sup>

**“Биеэ засаад гэрээ зас  
Гэрээ засаад төрөө зас”**

**Чингис хааны сургаал үг**

Харсаар байж бид өөрсдөө энэ байдлыг өөгшүүлээд байгаа юм биш биз. Хүнд суртал, эрх ямба, ялгаварлан гадуурхах, дарангуйлал чинь колоничлогдсон оронд тулгардаг зовлон биш гэж үү? Гэтэл ардчиллын замаар замнаж буй манай оронд яагаад ийм зүйлс оршоод байгааг тунгааж бодох сөхөө алга уу та минь ээ! Эсвэл нөгөө төрийн төлөө огтоно боож үхнэ гэсэн явган яриа хатгаад байгаа юм уу? (Таны хөнжил рүү бусад хүмүүс шагайж, орохыг нь та зөвшөөрөх үү?)

Социализмын гэгдэх нийгмээс ардчилал руу хөл тавьсан манай нийгэм ардчиллын үрийг суулгахдаа хуучин нийгмийн хог ургамлыг үндсээр нь ховхлон хаялгүй тарьсанд л хамаг учир оршино. Хорхойтож идээлсэн шүдийг ёзоороор нь авахгүй бол өвчин намддаггүйн адилаар, шинэ зүйлийг босгохдоо үндэс суурийг нь сайтар бэлтгэхгүй бол хожим хойно ч гэсэн хуучин зүйлс чимээгүйгээр байсаар эцэс сүүлд нь биднийг боолчлох болно.

Ардчиллаар халхавчилсан хүнд суртал, хайрцаглагдмал ойлголт, номинклатур анги бидний дунд оршоор л байна.

Хэн нэгнийхээ халаас руу өнгийж, гишгэсэн мөрийг нь мөрдөж, сорон мөлжих нь төөрөгдлөөс гаргах арга зам бус юм.

**“Монголчууд эвтэй байхдаа хүчтэй байдаг”**

Төр, иргэний нийгэм хоёр хоршин байхын хамт бие биесээ хянах нь хамгийн оновчтой шийдэл болов уу.

Дор бүрнээ хичээнгүйлэн хөдөлмөрлөж, өөрсдийн үнэт зүйлсийг бүтээн босгож, үүргээ ухамсарлаад, бусдын эрхэд халдаж халихгүй, хувийн эрх, эрх чөлөөгөө эдэлье хүмүүс ээ!

**“Төрийн минь сүлд өршөө”** гэсэн үзлээр мухарлахыг хүссэнгүй эл тод байгаа байдлыг шүүмжлэн тунгааав.

Энд хүргээд эссегээ өндөрлөе! Үзсэн, харсан, мэдэрсэн, уншсан бүхий л зүйлсээ оюун бодролтойгоо хамтад нь цаасан дээр сийрүүлэхийг хичээлээ. Уншигч авхай танд сонголт хийх эрхийг тань үлдээе, чадан ядан бичсэн эссе минь ногооноороо байгаа бол бичигч миний бие хичээнгүйлэн хүлцэл өчие.

**Таны оюуны мэлмий бат орших болтугай.**

- 
1. Г.Аюурзана “Орчин цагийн агуу их сэтгэгчид” УБ, 2002 он,186-р тал
  2. Ентимема “Чөлөөт хуудас” 2004/03
  3. Г.Аюурзана “Орчин цагийн агуу их сэтгэгчид” УБ, 2002 он, 22-р тал
  4. Г.Аюурзана “Орчин цагийн агуу их сэтгэгчид” УБ, 2002 он,161-р тал
  5. МУИС-ийн ХЗС-ийн 4Б оюутан Б.Баяраа “Иргэний нийгэмгүй ардчилал” эссе.УБ, 2003 он